



## “ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХК

### **Баянгол дүүрэг 20-р хороо Үйлдвэрийн баруун бүсэд байрлах Жимс, хүнсний ногоо боловсруулах “Газар шим үйлдвэр” ХК-ийн 2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

**Хянасан:**

Нийслэлийн Байгаль орчны газрын мэргэжилтэн:

/М.Батзолбоо/

**Хэрэгжилтийг тайлагнасан:**

“Газар шим үйлдвэр” ХК-ийн гүйцэтгэх захирал:

/Ц.Ганбат/

БОХАБЭА-н асуудал хариуцсан менежер:

/Ч.Оюунбилэг/

**2023 он**


## Агуулга

| № | Гарчиг  | Хуудас |
|---|---|--------|
| 1 | <p><b>Төслийн товч танилцуулга</b></p> <p>1.1 Төслийн товч танилцуулга</p> <p>1.2 Усны хэрэглээ</p> <p>1.3 Орчны хяналт шинжилгээ</p> <p>1.4 Хог хаягдал</p>  |        |
| 2 | <p><b>Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ</b></p> <p>2.1 Төслийн гол сөрөг нөлөөлөл</p> <p>2.2 Төслийн нөлөөллийг бууруулах арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ</p>   |        |
| 3 | <p><b>Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл</b></p> <p>3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэл</p> <p>3.1.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт</p> <p>3.1.2 Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний хэрэгжилт</p> <p>3.1.3 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт</p> <p>3.1.4 Химийн бодис болон осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт</p> <p>3.1.5 БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөвлөгөөний гүйцэтгэл</p> <p>3.1.6 БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх ажлын гүйцэтгэл</p> <p>3.2 Байгаль орчны хяналт шинжилгээ</p> |        |

## Нэг. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Төслийн ерөнхий мэдээлэл:

|   |   |
|---|---|
| Төслийн нэр:                              | Хүнсний ногооны нөөш, Газар шим үйлдвэр   |
| Төсөл хэрэгжүүлэгч:                       | "Газар шим үйлдвэр" ХК  |
| Улсын бүртгэлийн дугаар:                  | 9011110110  |
| Регистрийн дугаар:                        | 2577127   |
| Холбоо барих утас:                        | 99112827  |
| Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар: | 000013035<br>000087406  |
| Газрын зориулалт:                         | Аж ахуй, үйлдвэрлэл   |
| Эзэмшил газрын хэмжээ:                    | 1.3 га  |
| Төслийн байршил:                          | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, үйлдвэрийн бүс, "ДЦС-4" ТӨХК-ийн баруун хойд талд  |
| Төслийн зорилго:                          | <ul style="list-style-type: none"> <li>- MNS 5075:2001 стандартын шаардлага хангасан нөөшилсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, хүнсний салбарт үндэсний бренд бүтээгдэхүүнийг бий болгох</li> <li>- Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо-Хүнсний сүлжээний аливаа байгууллагад тавих шаардлага ISO 22000, Чанарын Менежментийн тогтолцоо ISO 9001 стандартыг байнга хангаж ажиллах</li> <li>- ISO17025 стандартыг нэвтрүүлж итгэмжлэгдэх</li> <li>- ISO 14001 стандартыг хангах</li> </ul> |
| Төслийн ач холбогдол:                     | <ul style="list-style-type: none"> <li>- Дотоодын хэрэглэгчдийн консервантгүй бүтээгдэхүүний хэрэгцээг тодорхой хувиар хангах</li> <li>- Ажлын байр нэмэгдүүлэх</li> <li>- Орон нутгийн болон улсын төсөвт тодорхой орлогыг нэмэгдүүлэх</li> </ul>  |
| Үйл ажиллагааны чиглэл, код:              | <ul style="list-style-type: none"> <li>- Жимс, хүнсний ногоо нөөшилсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэл</li> <li>- Ундааны үйлдвэрлэл</li> <li>- Дотоод хяналтын лаборатори</li> <li>- Органик хүлэмжийн аж ахуй</li> </ul>  |
| Төслийн хүчин чадал:                      | Жилдээ 56 нэр төрлийн 6-7.0 сая ширхэг орчим нөөшилсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.  |
| Ажиллах хүчин:                            | 211 ажилтан   |
| Дулаан хангамж:                           | Технологийн уурыг ДЦС-4   |
| Уур:                                      |   |
| Цахилгаан хангамж:                        | Улаанбаатар УБЦТС ТӨХК  |
| Ус хангамж:                               | Төвийн шугамд холбогдсон. Мөн гүний худагтай.   |
| Хатуу хог хаягдал:                        | БГД-ийн ТҮК-тэй гэрээтэй.   |



Зураг 1. Үйлдвэрийн байршил

Үйлдвэрийн бүтэц зохион байгуулалт:

“Газар шим үйлдвэр” ХК нь ундааны үйлдвэр, нөөшилсөн бүтээгдхүүний үйлдвэр, лаборатори, түүхий эд, материалын болон бэлэн бүтээгдхүүний агуулах, оффис, 14 машины гараж гэсэн үндсэн хэсгүүдтэй.



Зураг 2. Үйлдвэрийн гадна талын харагдах байдал



Зураг 3. Оффис



Зураг 4. Түүхий эд, бэлэн бүтээгдхүүний агуулах



Зураг 5. Харуулын байр

Зураг 6. Гараж



Зураг 7. Ногоон байгууламж

## 1.2. Ус хэрэглээ

Үйлдвэрийн усны хэрэглээг өөрийн эзэмшлийн гүний худаг болон төвийн шугамаас хангах гэрээтэй. Компанийн 2020 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг үндэслэн, БОНХАЖСайдын 2015 оны А/301 тушаалаар батлагдсан аргачлалын дагуу усны хэрэглээг тооцож компанийн баталгаажсан тоолуурын заалттай харьцуулав.

Унд, ахуйн хэрэглээ: Үйлдвэрт үндсэн 211 хүн жилийн 333 хоног, шинэ ногооны ургац хураалтын үеэр нэмэлтээр 150 хүн 70 хоног ажиллах ба хоногт нийт 72.2 м<sup>3</sup>, жилд 16.2 мян.м<sup>3</sup> усыг ажилчдын унд ахуйн хэрэгцээнд ашиглах тооцоотой.

Бусад хэрэглээ: Үйлдвэрийн технологийн хэрэгцээнд жилд 67.0 мян.м<sup>3</sup>, бусад буюу мод бут, зүлэг усалгаанд жилд 104.6м<sup>3</sup> ус, компаний хэмжээнд жилд нийт 83.3 мян.м<sup>3</sup> цэвэр ус ашиглах тооцоотой.

### Хүснэгт 1. Ажилчдын унд ахуйн усны хэрэглээ

| Хугацаа                                     | Хоногт хэрэглэх усны хэмжээ, л | Ажиллах хоног | Ажиллах хүчин, хүн | Усны хэрэглээ, м <sup>3</sup> |
|---|--------------------------------|---------------|--------------------|-------------------------------|
| Үндсэн                                      |                                |               |                    |                               |
| 1 хоног                                     | 200                            | 1             | 211                | 42.2                          |
| 1 жил                                       |                                | 333           |                    | 14052.6                       |
| 5 жил                                       |                                | 1665          |                    | 70263.0                       |
| Шинэ ногооны ургац хураалтын үеэр нэмэлтээр |                                |               |                    |                               |
| 1 хоног                                     | 200                            | 1             | 150                | 30.0                          |
| 1 жил                                       |                                | 70            |                    | 2100.0                        |
| 5 жил                                       |                                | 350           |                    | 10500.0                       |

БОНХАЖСайдын 2015 оны А/301 тушаалын 12 дугаар хавсралт, "Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм"-оор тооцов.

### Хүснэгт 2. 2020 оны үйлдвэрлэлийн хэмжээгээр ус ашиглалтын тооцоо

| Үйлдвэр               | Бүтээгдэхүүний нэр, хэмжих нэгж   | Хүнсний салбарын усны норм, м <sup>3</sup> | Үйлдвэрлэлийн хэмжээ, мян.ш | Ус ашиглалт, м <sup>3</sup> |
|-----------------------|-----------------------------------|--|-----------------------------|-----------------------------|
| Жимс, ногооны үйлдвэр | 1000ш 0.75л шилэнд жимсний компот | 7.1  | 756.2                       | 5369.0                      |
|                       | 1000ш 0.75л шилэнд хүнсний ногоо  | 9.6  | 6201.0                      | 59530.0                     |
| Ундааны үйлдвэр       | 1000л ундаа Артишок ундаа 280мл   | 12.5                                       | 605.1ш/169.4л               | 2117.5                      |
| Нийт                  |                                   |  | 7562.3                      | 67017.2                     |

БОНХАЖСайдын 2015 оны А/301 тушаалын 3 дугаар хавсралт, "Хүнсний салбарын усны норм"-оор тооцов.

### Хүснэгт 3. Зүлэг усалгааны усны тооцоо

| Усалгааны төрөл             | Хугацаа           | Усалтын норм, л | Услах хоног, удаа | Услах талбай       | Ус хэрэглээ, м <sup>3</sup> |
|-----------------------------|-------------------|-----------------|-------------------|--------------------|-----------------------------|
| Цэцэрлэг, зүлэг ногоо услах | 1 хоног           | 4               | 1                 | 345 м <sup>2</sup> | 1.38                        |
|                             | 1 сар             |                 | 8                 |                    | 11.0                        |
|                             | 1 жил (5-10 сард) |                 | 48                |                    | 66.24                       |
|                             | 5 жил             |                 | 240               |                    | 331.2                       |
| Суулгац усалгаа             | 1 хоног           | 40              | 1                 | 20 ш мод1,38       | 0.8                         |
|                             | 1 сар             |                 | 8                 |                    | 6.4                         |
|                             | 1 жил (5-10 сард) |                 | 48                |                    | 38.4                        |
|                             | 5 жил             |                 | 240               |                    | 192.0                       |

БОНХАЖСайдын 2015 оны А/301 тушаалын 13 дугаар хавсралт, "Зүлэгжүүлэлт, зам талбайн усалгааны усны норм"-оор тооцов.

Хүснэгт 4. Үйлдвэрийн нийт усны хэрэглээ

| Хугацаа | Ажилчдын унд ахуй | Үйлдвэрийн ус ашиглалт | Зүлэг усалгаа | Суулгац усалгаа | Нийт ус хэрэглээ, м <sup>3</sup> |
|---------|-------------------|------------------------|---------------|-----------------|----------------------------------|
| 1 хоног | 72.2              | 183.6                  | 1.4           | 0.8             | 258.0                            |
| 1 жил   | 16152.6           | 67017.2                | 66.2          | 38.4            | 83273.7                          |
| 5 жил   | 80763.0           | 335083.3               | 331.2         | 192.0           | 416368.7                         |

БОНХАЖСайдын 2015 оны А/301 тушаал "Чэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-оор тооцсон дүнтэй компанийн усны тоолуурын заалтыг харьцуулсан тооцоогоор нормын дагуу 83.3 мян.м<sup>3</sup> ус ашиглах байснаас 2020 оны тоолуурын заалтаар нийт 76.0 мян.м<sup>3</sup> ашигласан нь 7.2 мян.м<sup>3</sup> ус хэмнэсэн буюу нормоос 1.1 дахин бага ус ашигласан байна.

Хүснэгт 5. Хүнсний салбарын усны нормыг "ГБТ трейдинг" ХХК-ийн усны хэрэглээтэй харьцуулсан харьцуулалт


| Хугацаа | Компаний усны тоолуураар баталгаажсан 2020 оны ус ашиглалтын хэмжээ, м <sup>3</sup> | А/301 Хүнсний салбарын усны нормоор тооцсон нийт ус ашиглалт, м <sup>3</sup> | Зөрүү ус хэмнэлт, м <sup>3</sup> |
|---------|---|--|----------------------------------|
| 1 хоног | 208.3   | 258.0  | 49.7                             |
| 1 жил   | 76030   | 83273.7  | 7243.7                           |
| 5 жил   | 380150  | 416368.7   | 36218.7                          |

1.3.Орчны хяналт, шинжилгээ

*а. Усны чанар, шинжилгээ*

I. Шугамын усны ерөнхий шинжилгээ

Лабораторийн цэвэрлэгээ, оффисын ажилчдын унд ахуйн хэрэглээнд ашиглах шугамын уснаас 2021 оны 04 сарын 27-ны өдөр дээж авч "НАРТ ШУУН КОНСАЛТИНГ" ХХК-ний лабораторид шинжлүүлэв. Тус компани нь хэрэглээний хаягдал усыг "Ус сувгийн удирдах газар"-тай байгуулан гэрээний дагуу төвлөрсөн шугам сүлжээнд нийлүүлдэг.



Зураг 8. Усны шинжилгээний дээж авч буй байдал

Хүснэгт 6. Усны химийн шинжилгээний дүн

| Анион                         | MNS 0900:2018 | 1 дм <sup>3</sup> -д байгаа |        |            | Катион           | MNS 0900:2018 | 1 дм <sup>3</sup> -д байгаа |        |            |
|-------------------------------|---------------|-----------------------------|--------|------------|------------------|---------------|-----------------------------|--------|------------|
|                               |               | мг                          | мг-экв | % мг-экв/л |                  |               | мг                          | мг-экв | % мг-экв/л |
| CO <sub>3</sub> <sup>2-</sup> | -             | 0.0                         | 0.0    | 0.0        | Na <sup>+</sup>  | -             | 19.8                        | 0.86   | 17.60      |
| HCO <sub>3</sub> <sup>-</sup> | -             | 184.00                      | 3.02   | 61.67      | K <sup>+</sup>   | -             |                             |        |            |
| Cl <sup>-</sup>               | 350.0         | 47.00                       | 1.33   | 27.11      | Ca <sup>++</sup> | 100.0         | 61.0                        | 3.04   | 62.22      |
| SO <sub>4</sub> <sup>2-</sup> | 500.0         | 21.00                       | 0.44   | 8.94       | Mg <sup>++</sup> | 30.0          | 12.00                       | 0.99   | 20.18      |
| NO <sub>3</sub> <sup>-</sup>  | 50.0          | 6.90                        | 0.11   | 2.28       |                  |               | 92.8                        | 4.89   | 100        |
| Дүн                           | -             | 258.9                       | 4.89   | 100        |                  | -             |                             |        |            |

Хүснэгт 7. Усны физик шинж чанар

| Усны эх үүсвэр | НСO <sub>3</sub> -ийн хагасыг хассан анион, катионуудын нийлбэр. Мг/л | Анион, катионуудын нийлбэр. Мг/л | Физик үзүүлэлтүүд        |      |                                |          |                      |            |            |           |               |          |
|----------------|---|----------------------------------|--------------------------|------|--------------------------------|----------|----------------------|------------|------------|-----------|---------------|----------|
|                |   |                                  | Ерөнхий хатуулаг, мг-экв | pH   | Цахилгаан дамжуулах чанар ds/m | TDS, ppm | Хуурай үлдэгдэл, ppm | Өнгө, град | Үнэр, балл | Амт, балл | Бултгар, мг/л | Тунгалаг |
| Шугам          | 259.7   | 351.7                            | 4.03                     | 7.00 | 0.508                          | 302      | 248                  | үгүй       | 0          | 0         | үгүй          | +        |

Шугамын усны шинжилгээний дүнгээр гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, 2-р төрлийн, цэнгэг буюу дунд зэрэг эрдэжилттэй, бага хатуулагтай ус байна. Шинжилсэн үндсэн үзүүлэлтүүд нь "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018" стандартын шаардлага хангаж байна.

II. Худгийн усны чанар, шинжилгээ

Худгийн усны шинжилгээг 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр "Нарт шуун консалтинг" ХХК-ний хөрсний итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэв.



Зураг 9. Гүний худаг

Хүснэгт 8. Усны химийн шинжилгээний дүн

| Анион                         | MNS 0900:2018 | 1 дм <sup>3</sup> -д байгаа |        |            | Катион           | MNS 0900:2018 | 1 дм <sup>3</sup> -д байгаа |        |            |
|-------------------------------|---------------|-----------------------------|--------|------------|------------------|---------------|-----------------------------|--------|------------|
|                               |               | мг                          | мг-экв | % мг-экв/л |                  |               | мг                          | мг-экв | % мг-экв/л |
| CO <sub>3</sub> <sup>-</sup>  | -             | 0.0                         | 0.0    | 0.0        | Na <sup>+</sup>  | -             | 13.00                       | 0.57   | 12.34      |
| HCO <sub>3</sub> <sup>-</sup> | -             | 144.0                       | 2.36   | 51.52      | K <sup>+</sup>   | -             |                             |        |            |
| Cl <sup>-</sup>               | 350.0         | 40.00                       | 1.13   | 24.63      | Ca <sup>++</sup> | 100.0         | 64.00                       | 3.19   | 69.70      |
| SO <sub>4</sub> <sup>-</sup>  | 500.0         | 51.00                       | 1.06   | 23.18      | Mg <sup>++</sup> | 30.0          | 10.00                       | 0.82   | 17.96      |
| NO <sub>3</sub> <sup>-</sup>  | 50.0          | 1.90                        | 0.03   | 0.67       | Дүн              | -             | 87.0                        | 4.58   | 100        |
| Дүн                           | -             | 236.9                       | 4.58   | 100        |                  |               |                             |        |            |



Хүснэгт 9. Усны физик шинж чанар

| Усны эх үүсвэр | НСО <sub>3</sub> -ийн хагасыг хассан анион, катионуудын нийлбэр. Мг/л | Анион, катионуудын нийлбэр. Мг/л | Физик үзүүлэлтүүд        |      |                                |          |                      |            |            |           |               |          |
|----------------|---|----------------------------------|--------------------------|------|--------------------------------|----------|----------------------|------------|------------|-----------|---------------|----------|
|                |   |                                  | Ерөнхий хатуулаг, мг-экв | рН   | Цахилгаан дамжуулах чанар ds/m | TDS, ppm | Хуурай үлдэгдэл, ppm | Өнгө, град | Үнэр, балл | Амт, балл | Бултгар, мг/л | Тунгалаг |
| Худаг          | 251.8   | 323.8                            | 4.01                     | 6.51 | 0.567                          | 292      | 214                  | үгүй       | 0          | 0         | үгүй          | +        |

Хүснэгт 10. Усны эрүүл ахуйн шинжлгээний дүн

| Усны эх үүсвэр | Нянгийн тоо | Гэдэсний савханцрын титр (E.coli) | Анаэробын (Cl.perfringens) |
|----------------|-------------|-----------------------------------|----------------------------|
| Худгийн ус     | 3           | Илрээгүй                          | Илрээгүй                   |

Худгийн усны шинжилгээний дүнгээр химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, 1-р төрлийн, цэнгэг буюу дунд зэрэг эрдэсжилттэй, бага хатуулагтай ус байна. Шинжилсэн үндсэн үзүүлэлтүүд нь "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018" стандартын шаардлага хангаж байна.

III. төвлөрсөн шугамын усны шинжилгээ.

Төвлөрсөн шугамын усны шинжилгээг 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдөр дээж "Монгол-ус" ТӨҮГ-ын Усны хяналтын төв лабораторид шинжлүүлсэн байна. Шинжилгээний дүнг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 11. Дээжний тэмдэглэл

| Шинжилгээний тодорхойлолт | Цэвэр усны хими                                     | Цэвэр усны микробиологи |
|---------------------------|---|-------------------------|
| Дээжний дугаар            | №226  |                         |
| Дээжний хаяг, байршил     | УБ хот, БГД, 20 дугаар хороо, Үйлдвэрийн баруун бүс |                         |
| Уст цэгийн төрөл          | Төвлөрсөн шугам                                     |                         |
| Дээжний хэмжээ            | 1.5л  | 0.5л                    |
| Дээж хүлээн авсан огноо   | 2021.03.17  |                         |
| Шинжилсэн огноо           | 2021.03.17-0.3.23                                   |                         |
| Техникийн шаардлага       | MNS 0900:2018                                       |                         |

Хүснэгт 12. Төвлөрсөн шугамын усны микробиологийн шинжилгээний дүн

| № | Шинжилсэн үзүүлэлт, хэмжих нэгж  | Шинжилгээний аргын стандарт | ЗДХ      | Үр дүн   |
|---|--|-----------------------------|----------|----------|
| 1 | Нийт нянгийн тоо   | MNS ISO 6222:1998           | <100     | 90       |
| 2 | Гэдэсний бүлгийн савханцар, халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн савханцар | MNS ISO 9308-2:1998         | Илрэхгүй | Илрэхгүй |
| 3 | Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч бичил биетэн-Salmonella, Shigella          | MNS 6240:03                 | Илрэхгүй | Илрэхгүй |
| 4 | Сульфид задлагч агааргүйтэн-CI. perfringens                              | MNS 6461-1:1999             | Илрэхгүй | Илрэхгүй |
| 5 | Псевдомонас аерогиноза   | MNS 6546:2015               | Илрэхгүй | Илрэхгүй |

**Хүснэгт 13. Төвлөрсөн шугамын усны химийн шинжилгээний дүн**

| №  | Үзүүлэлт  | Шинжилгээний аргын стандарт | ЗДХ     | Үр дүн |
|----|---|-----------------------------|---------|--------|
| 1  | pH-Усны орчин   | MNS ISO 10523:2001          | 6.5-8.5 | 6.71   |
| 2  | Цахилгаан дамжуулах чадвар, мСм/см                    | MNS ISO 7888:1999           | <1.0    | 0.64   |
| 3  | Ерөнхий хатуулаг, мг-экв/л                            | MNS ISO 6059:2005           | <7.0    | 5.6    |
| 4  | Кальци, (Ca <sup>2+</sup> ) мг/л                      | MNS 1097:1970               | <100.0  | 80.96  |
| 5  | Магни, (Mg <sup>2+</sup> ) мг/л                       | MNS 1097:1970               | <30.0   | 18.97  |
| 6  | Карбонат, (CO <sub>3</sub> <sup>-</sup> ) мг/л        | MNS 9963-1:2005             | -       | 0.00   |
| 7  | Хлорид, (Cl <sup>-</sup> ) мг/л                       | MNS ISO 9297:2005           | <350.0  | 39.70  |
| 8  | Гидрокарбонат, (HCO <sub>3</sub> <sup>-</sup> ) мг/л  | MNS ISO 9963-1:2005         | -       | 170.80 |
| 9  | Нитрит, (NO <sub>2</sub> <sup>-</sup> ) мг/л          | MNS ISO 4431:2005           | <1.0    | 0.007  |
| 10 | Нитрат, (NO <sub>3</sub> <sup>-</sup> ) мг/л          | MNS ISO 7890-3:2001         | <50.0   | 14.73  |
| 11 | Төмөр (Fe <sup>3+</sup> ) мг/л                        | MNS 4430:2005               | <0.3    | 0.34   |
| 12 | Сульфат, (SO <sub>4</sub> <sup>2-</sup> ) мг/л        | MNS 6271:2011               | <500    | 85.53  |
| 13 | Хуурай үлдэгдэл, мг/л                                 | MNS 4423:1997               | <1000.0 | 423.00 |
| 14 | Натри+Кали, (Na <sup>+</sup> , Ka <sup>+</sup> ) мг/л | MNS 1097:1970               | <200    | 7.82   |
| 15 | Аммони, (NH <sub>4</sub> <sup>+</sup> ) мг/л          | MNS 1097:1970               | <1.5    | 0.52   |

Шинжилгээний дүнгээр химийн найрлагын хувьд стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй үзүүлэлттэй байна.

**IV. Шүүсэн усны шинжилгээ**

Шүүсэн усны шинжилгээг 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдөр дээж авч "Монгол- ус" ТӨҮГ-ын Усны хяналтын төв лабораторид шинжлүүлсэн байна. Шинжилгээний дүнг дараах хүснэгтээр харуулав.

**Хүснэгт 14. Дээжний тэмдэглэл**

| Шинжилгээний тодорхойлолт | Цэвэр усны хими                                     | Цэвэр усны микробиологи |
|---------------------------|---|-------------------------|
| Дээжний дугаар            | №225  |                         |
| Дээжний хаяг, байршил     | УБ хот, БГД, 20 дугаар хороо, Үйлдвэрийн баруун бүс |                         |
| Уст цэгийн төрөл          | Шүүсэн ус   |                         |
| Дээжний хэмжээ            | 5.0л  | 0.5л                    |
| Дээж хүлээн авсан огноо   | 2021.03.17  |                         |
| Шинжилсэн огноо           | 2021.03.17-0.3.23                                   |                         |
| Техникийн шаардлага       | MNS 0900:2018                                       |                         |

**Хүснэгт 15. Шүүсэн усны микробиологийн шинжилгээний дүн**

| № | Шинжилсэн үзүүлэлт, хэмжих нэгж  | Шинжилгээний аргын стандарт | ЗДХ      | Үр дүн   |
|---|--|-----------------------------|----------|----------|
| 1 | Нийт нянгийн тоо   | MNS ISO 6222:1998           | < 100    | 0        |
| 2 | Гэдэсний бүлгийн савханцар, халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн савханцар | MNS ISO 9308-2:1998         | Илрэхгүй | Илрэхгүй |
| 3 | Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч бичил биетэн-Salmonella, Shigella          | MNS 6240:03                 | Илрэхгүй | Илрэхгүй |
| 4 | Сульфид задлагч агааргүйтэн-Cl.perfri- gens                              | MNS 6461-1:1999             | Илрэхгүй | Илрэхгүй |
| 5 | Псевдомонас аерогиноза   | MNS 6546:2015               | Илрэхгүй | Илрэхгүй |

Хүснэгт 16. Шүүсэн усны химийн шинжилгээний дүн

| №  | Үзүүлэлт   | Шинжилгээний аргын стандарт | ЗДХ     | Үр дүн |
|----|--|-----------------------------|---------|--------|
| 1  | pH-Усны орчин  | MNS ISO 10523:2001          | 6.5-8.5 | 6.93   |
| 2  | Цахилгаан дамжуулах чадвар, мСм/см                   | MNS ISO 7888:1999           | <1.0    | 0.64   |
| 3  | Ерөнхий хатуулаг, мг-экв/л                           | MNS ISO 6059:2005           | <7.0    | 5.12   |
| 4  | Кальци, (Ca <sup>2+</sup> ) мг/л                     | MNS 1097:1970               | <100.0  | 81.36  |
| 5  | Магни, (Mg <sup>2+</sup> ) мг/л                      | MNS 1097:1970               | <30.0   | 12.89  |
| 6  | Карбонат, (CO <sub>3</sub> <sup>-</sup> ) мг/л       | MNS 9963-1:2005             | -       | 0.00   |
| 7  | Хлорид, (Cl <sup>-</sup> ) мг/л                      | MNS ISO 9297:2005           | <350.0  | 41.83  |
| 8  | Гидрокарбонат, (HCO <sub>3</sub> <sup>-</sup> ) мг/л | MNS ISO 9963-1:2005         | -       | 152.50 |
| 9  | Нитрит, (NO <sub>2</sub> <sup>-</sup> ) мг/л         | MNS ISO 4431:2005           | <1.0    | 0.00   |
| 10 | Нитрат, (NO <sub>3</sub> <sup>-</sup> ) мг/л         | MNS ISO 7890-3:2001         | <50.0   | 18.75  |
| 11 | Төмөр (Fe <sup>3+</sup> ) мг/л                       | MNS 4430:2005               | <0.3    | 0.05   |
| 12 | Сульфат, (SO <sub>4</sub> <sup>2-</sup> ) мг/л       | MNS 6271:2011               | <500    | 75.53  |
| 13 | Хуурай үлдэгдэл, мг/л                                | MNS 4423:1997               | <1000.0 | 447.00 |
| 14 | Натри+Кали, (Na <sup>+</sup> , K <sup>+</sup> ) мг/л | MNS 1097:1970               | <200    | 9.89   |
| 15 | Аммони, (NH <sub>4</sub> <sup>+</sup> ) мг/л         | MNS 1097:1970               | <1.5    | 0.49   |

Шүүсэн усны шинжилгээний дүнгээр химийн найрлага төдийлөн өөрчлөлтгүй, зарим үзүүлэлт бага зэрэг буурч, стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй хэвийн үзүүлэлттэй гарсан байна.

V. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усны шинжилгээний дүн

Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усны шинжилгээг 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдөр "Ус сувгийн удирдах газар"-ын "Усны лаборатори"-д шинжлүүлсэн шинжилгээний дүнг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 17. Дээжний тэмдэглэл

|                           |   |
|---------------------------|---|
| Шинжилгээний тодорхойлолт | Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус    |
| Дээжний дугаар            | Б-1426  |
| Дээжний хаяг, байршил     | УБ хот, БГД, 20 дугаар хороо, Үйлдвэрийн баруун бүс |
| Протоколын дугаар         | 132   |
| Дээжний хэмжээ            | 1.5л  |
| Шинжилсэн огноо           | 2020.09.30-10.05                                    |
| Техникийн шаардлага       | MNS 6561:2015                                       |

Хүснэгт 18. Хаягдал усны химийн шинжилгээний дүн

| Шинжилгээний аргын стандарт | Шинжилсэн үзүүлэлт        | Нэгж                | MNS 6561:2015 ЗДХ | Б-1426 |
|-----------------------------|---------------------------|---------------------|-------------------|--------|
| MNS ISO 10523:2001          | Усны орчин pH             | -                   | 6.0-9.0           | 6.68   |
| MNS ISO 7888:1999           | Цахилгаан дамжуулах чанар | uS/cm               | -                 | 613    |
| MNS ISO 5815-1:2015         | Биохимийн хэрэгцээт       | мгО <sub>2</sub> /л | 400               | 127.5  |
| MNS ISO 5815-2:2015         | хүчилтөрөгч               |                     |                   |        |
| MNS ISO 11923:2001          | Умбуур бодис (жинлэгдэх)  | мг/л                | 400               | 9      |

|                     |                        |                                 |      |       |
|---------------------|------------------------|---------------------------------|------|-------|
| MNS 1097:1970       | Аммони                 | м <sup>^</sup> Н <sub>4</sub> Д | 15   | 4.85  |
| MNS ISO 6060:2001   | Химийн хэрэгцээт хүчил | мгО <sub>2</sub> /л             | 800  | 1245  |
| MNS ISO 6777:2001   | Нитрит                 | мгNO <sub>2</sub> /л            | -    | 0.137 |
| MNS ISO 7890-3:2001 | Нитрат                 | мгNO <sub>3</sub> /л            | -    | 17.56 |
| MNS ISO 9297:2005   | Хлорид                 | мг/л                            | 1000 | 29.29 |
| MNS ISO 9963-1:2005 | Холимог шүлтлэг        | ммоль/л                         | -    | 0     |
| MNS ISO 9963-1:2005 | Нийт шүлтлэг           | ммоль/л                         | -    | 2.31  |
| MNS ISO 6878:2001   | Ортофосфат             | мгPO <sub>4</sub> -P/л          | -    | 0.27  |
| СХА-СА3-21          | Сульфат                | мг/л                            | 700  | 135.8 |

Хаягдал усны шинжилгээний дүнгээр Химийн хэрэгцээт хүчилтөрөгч (XXX)-ийн хэмжээ "Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага" MNS 6561:2015 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 1.5 дахин хэтэрсэн үзүүлэлттэй гарсан.

### б. Хөрсний чанар, шинжилгээ

Судалгааны ажлын хүрээнд нэгж талбарын хөрсний бохирдол, доройтлыг тодорхойлох зорилгоор эзэмшил газрын 1 цэгээс хүнд металлын дээж авч "НАРТ ШУҮН КОНСАЛТИНГ" ХХК-ний Хөрсний итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэв.



Зураг 10. Хөрсний дээж авч буй байдал

### Хүснэгт 19. Хөрсний дээж авсан тэмдэглэл

|                             |                            |
|-----------------------------|----------------------------|
| Дээжний дугаар              | Дээж №1                    |
| Сорьц авсан гүн             | 0~10см                     |
| Хөрсний өнгө                | Цайвар хүрэн               |
| Сорьц авсан цэг             | Үйлдвэрийн хойд талбайгаас |
| Сорьц авсан цэгийн солбицол | 47.899316°<br>106.795029°  |
| Дээжний төрөл               | Хүнд металл                |

### Хүснэгт 20. Хөрсний хүнд металлын үзүүлэлтүүд

| Дээж авсан газар | Дээж авсан гүн, см | Хүнд металлын агууламж |      |     |      |      |      |
|------------------|--------------------|------------------------|------|-----|------|------|------|
|                  |                    | Cr                     | Pb   | Cd  | Zn   | Cu   | Ni   |
| Дээж 1           | 0-20               | 59.1                   | 18.2 | 0.0 | 24.5 | 25.3 | 14.0 |
| MNS 5850:2019    | Элсэрхэг хөрс      | 60                     | 50   | 1   | 100  | 60   | 60   |
|                  | Шавранцар хөрс     | 100                    | 70   | 1.5 | 150  | 80   | 100  |
|                  | Шаварлаг хөрс      | 150                    | 100  | 3   | 300  | 100  | 150  |

Хөрсөн дэх хүнд металлын агууламж "MNS 5850:2019" стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй байна.

### в. Агаарын чанар, шинжилгээ

2021 оны 08 дугаар сарын 25-ны өдөр үйлдвэрийн гадна агаарын чанар, физик бохирдол болон савлагаа, шил угаах хэсэгт дуу чимээ тодорхойлохоор ЦУОШГ-ын төв лаборатори дараах аргачлалын дагуу хэмжилт хийсэн болно.



Зураг 11. Хэмжилт хийж буй байдал  
А. Орчны агаар, Б. Дуу чимээ

Хүснэгт 21. Агаарын чанарын хэмжилтийн дүн

| № | Сорьц авсан цэг  | SO <sub>2</sub> , мг/м <sup>3</sup> | NO <sub>2</sub> , мг/м <sup>3</sup> | Нийт тоосны агууламж, мг/м <sup>3</sup> | Дуу чимээ (ДБА) |
|---|--|-------------------------------------|-------------------------------------|---|-----------------|
| 1 | Үйлдвэрийн гадна талбай  | 0.013                               | 0.072                               | 0.148                                   | 56              |
|   | "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" MNS 4585:2016   | 0.450                               | 0.200                               | 0.500                                   | 60              |
| 2 | Савлагааны хэсэг   | -                                   | -                                   | -                                       | 86              |
| 3 | Шилний хэсэг   | -                                   | -                                   | -                                       | 90              |
|   | "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, Шуугианы норм, Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага" MNS 5002:2000 |                                     |                                     |   | 85              |

Шинжилгээний үр дүнг "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" MNS 4585:2016 стандарттай харьцуулахад үйлдвэр, түүний орчмын агаар дахь SO<sub>2</sub>, NO<sub>2</sub>, нийт тоосны агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй хэвийн, харин дуу чимээний үзүүлэлт өндөр байна. Мөн савлагаа, шил угаах хэсгийн дуу чимээний шинжилгээний дүнг "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, Шуугианы норм, Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага" MNS 5002:2000 стандарттай харьцуулахад хүлцэх хэмжээнээс 1 дахин хэтэрсэн байна.

1.4. Хог хаягдал

Аюултай хог хаягдал:

Үйлдвэрт ашиглагддаг химийн бодисын сав баглаа боодол, хуванцар савнаас 380 кг, шуудайны хаягдал 15 кг гарах тооцоотой. Лабораторийн хэмжээнд маш бага бодис хэрэглэгддэг тул гарах шил савны хаягдлыг дотоодын импортлогч аж ахуйн нэгжүүдэд буцаан нийлүүлдэг.

Энгийн ахуйн хог хаягдал: Төслийн үйл ажиллагаанаас үйлдвэр, түүхий эд болон бэлэн бүтээгдэхүүний агуулах, лаборатори, оффис болон ажилчдын ахуйн хэрэглээнээс жилд

дунджаар нийт 15-20 орчим төрлийн 320 тн хог хаягдал үүсдэг. Хог хаягдлыг эх үүсвэрээс нь ангилан доорх хүснэгтэд харуулав.



Зураг 12. Үйлдвэрээс гарах хог хаягдлууд



Зураг 13. Гадна хогийн сав

## Хүснэгт 22. Жилд гарах нийт хог хаягдлын хэмжээ

| Ангилал                | Хог хаягдлын код | Хог хаягдлын төрөл  | Хэмжээ, кг              | Тайлбар  |
|------------------------|------------------|---|-------------------------|--|
| Хатуу, тн              | 15 01 01         | Цаас, картонон сав баглаа боодол  | 27374.85                | Баянгол Шинэ Өргөө ОНӨААТҮГ гэрээний дагуу зайлуулна   |
|                        | 15 01 07         | Шилэн сав   | 28271                   |  |
|                        | 15 01 05         | Гялгар уут  | 3300                    |  |
|                        | 15 01 03         | Модон сав баглаа боодол /Поддон, торх/                                  | 114504                  | Дахин ашиглана   |
|                        | 15 01 02         | Хуванцар сав баглаа боодол  | 2513.42                 | Хоёрдогч түүхий эд авах цэг  |
|                        | 15 01 06         | Холимог сав баглаа боодлын хаягдал/шуудай/                              | 24800                   | Хогийн уут зориулалтаар дахин ашиглах  |
|                        | 02 01 01         | Цэвэрлэгээний лаг шаар  | 4500                    | -  |
|                        | 02 03 02         | Нөөшлөгч бодисын хаягдал  | 13500                   | Хаягдал болон акталсан бүтээгдэхүүн худалдан авах гэрээний дагуу                                 |
|                        | 02 03 01         | Угаах, цэвэрлэх, хальслах, тунгаах, ялгахад үүсэх хаягдал               |                         |  |
|                        | 20 01 04         | Хаягдал маск, бээлий  | 3066.9                  | -  |
|                        | 15 01 04         | Металл сав баглаа боодол /бочки, таг/                                   | 220                     | Хаягдал төмөр авдаг түүхий эдийн цэгт тушаах   |
|                        | 16 01 14         | Төмрийн хаягдал   | 2500                    |  |
|                        | 20 03 01         | Ахуйн холимог хог хаягдал   | 90 000                  | <Баянгол Шинэ Өргөө> ОНӨААТҮГ гэрээний дагуу зайлуулна.  |
| Хортой/Аюултай         | 15 01 09*        | Химийн бодисын сав баглаа боодлын хаягдал<br>- хуванцар сав<br>- шуудай | 380 кг<br>15 кг         | Эко-лабораторид нийлүүлэх (Лабораторийн шил сав) «Түмэн эгшиг» ХХК-тай гэрээ байгуулж нийлүүлнэ. |
| Шингэн, м <sup>3</sup> | Б-0702           | Хаягдал ус  | 47.9 мян.м <sup>3</sup> | Ус сувгийн удирдах газартай гэрээний дагуу төв цэвэрлэх байгууламжид нийлүүдэг.                  |
|                        | Ө-1002           |   |                         |  |
| Нийт                   |                  |   |                         | 314.9-320 тн (хатуу)<br>47.9-50.0 мян.м <sup>3</sup> (шингэн)                                    |

Үйлдвэрээс гарч буй ахуйн хатуу хог хаягдлыг харъяа дүүргийн буюу “Баянгол Шинэ Өргөө” ОНӨААТҮГ Нийтлэг үйлчилгээний албанд нийлүүлдэг.

Хог хаягдлын менежментийн хүрээнд аль болох байгальд шууд булшлах, хаях биш дахин боловсруулах үйлдвэрүүдтэй хамтран ажиллах, хаягдлын хэмжээг бууруулах арга хэмжээ авч ажилладаг бөгөөд хог хаягдлын 90%-ийг дахин ашигладаг. Ногооны хальс, үлдэгдлийг амьтны тэжээлд, картон цаасан хайрцаг болон төмрийн хаягдлуудыг дахин

боловсруулах иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад гэрээ байгуулан нийлүүлдэг (Иргэн, ААН-үүдтэй хийсэн гэрээг хавсаргав).

## Хоёр. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

### 2.1 Төслийн гол сөрөг нөлөөлөл

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, байгаль орчны хяналт-шинжилгээ, үйл ажиллагааны явцад технологийн үе шатуудтай холбоотой үүсч болзошгүй сөрөг нөлөөллүүдийг дараах байдлаар тодорхойлов.

Хүснэгт 23. Сөрөг нөлөөлөл

|         |   |
|---------|---|
| Агаар   | <ul style="list-style-type: none"> <li>- Тээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулагч бодисууд</li> <li>Төслийн үйл ажиллагааны ачааллаас шалтгаалан жилд 11.2 тн органик бус тоос (CO, NO<sub>2</sub>, SO<sub>2</sub>) ялгарах тооцоотой.</li> <li>- Хог хаягдлын цэгээс үүсэх үнэрийн бохирдол</li> <li>- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихтэй, салхи шуурга ихтэй үед тоосжилт үүсэх</li> </ul>   |
| Хөрс    | <ul style="list-style-type: none"> <li>- Ажилчдын ахуйн хатуу хог хаягдал, бохир ус хөрсөн дээр ил задгай хаях асгах буюу хадгалвал хөрс бохирдуулах эх үүсвэр болно.</li> <li>- Зориулалтын зам талбайд тээврийн хэрэгсэл байрлуулаагүй, замбараагүй автомашины хөдөлгөөнөөс хөрс талхлагдах, хүнд металаар бохирдуулна.</li> </ul>  |
| Ургамал | <ul style="list-style-type: none"> <li>- Төслийн үйл ажиллагааны үед хатуу хог хаягдлыг хөрсөн дээр ил задгай хаях, эвдэрсэн газрыг сэргээн хөрсжүүлэх ажлыг орхигдуулах зэрэг үйл ажиллагаа нь хөрсийг бохирдуулж ургамлын бүтцийг өөрчлөн доройтуулах, улмаар ургац хомсдох нөхцөл болно. Тухайн орчны хөрс үйл ажиллагааны улмаас бохирдохын хирээр ургамлан нөмрөгт тодорхой хэмжээгээр өөрчлөлт гарах бөгөөд үүнтэй уялдан ургамал идэшт мэрэгч амьтдын амьдрах орчин доройтож, идэш тэжээлийн хомсдол үүсч болзошгүй.</li> </ul>  |
| Ус      | <p>Төслийн талбайд явуулах аливаа үйл ажиллагаа ургамлын бүрхэвчийг доройтуулж, хөрсийг дагтаршуулах, элэгдүүлэх, эвдлэх зэргээс болж үерийн урсацын коэффициентийг ихэсгэнэ. Энэ нь үерийн урсацыг нэмэгдүүлэх эрсдэлтэй бөгөөд үйлдвэрийн талбай усанд автах, ус тогтох гэх мэт болзошгүй сөрөг нөлөөтэй.</p> <p>Төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн газрын доорх усанд дараах сөрөг нөлөөллийг үзүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Цэнгэг усны нөөцийг ашиглах;</li> <li>- Газрын доорх уст давхаргууд болон тухайн орчин дахь булгуудын гидравлик холбоо алдагдаж газрын доорх усны нөөцийн хомсдол үүсч болзошгүй;</li> <li>- Хог хаягдал, химийн бодис, шатах, тослох материал, бохир усны алдагдал, нэвчилтээс бага гүний уст үеүд бохирдож болзошгүй.</li> </ul> <p>Төслийн байршил нь Туул голоос 2 км, голын энгийн хамгаалалтын бүсээс 1.4 км, онцгой хамгаалалтын бүсээс 1.8 км зайд орших бөгөөд БОНХАЖС, БХБС-ын хамтарсан 2015 оны А-230/127 дугаар тушаал, Усан сан бүхий газар, Усны эх үүсвэрийн онцгой болон, энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журамтай зөрчилдөхгүй.</p> |



2.2. Төслийн гол сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Хүснэгт 24. Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

| № | Арга хэмжээний чиглэл                        | Зөвлөмж  | Үр дүн   |
|---|--|--|--|
| 1 | Усны менежментийг саижруулах чиглэлээр       | Хаягдал усны дүгнэлтийг тухайн жилийн эхний улиралд багтаан гаргуулах  | Усны тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт хангагдана.  |
|   |  | Улирал бүр 2-оос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, зөвхөн байгаль орчны итгэмжпэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж хариу дүнг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны өдрийн дотор Усны газарт хүргүүлж байх  | -Хаягдал усыг цэвэрлэж, эргүүлэн үйлдвэр, үйлчилгээнд ашигласан бол дахин ашигласан хэмжээгээр,  |
|   |  | "Хаягдал уснаас дээжпэлт хийх удирдамж" MNS ISO 5667-10:2001 стандартад заасны дагуу хаягдал уснаас 2 цагийн завсарлагатайгаар 24 цагийн дотор холимог дээж авах гар эсвэл автомат ажиллагаатай төхөөрөмжтэй байна.  | - Хаягдал усыг усны чанар стандартын хэмжээнд хүртэл цэвэрлэсэн хэмжээгээр,  |
|   |  | MNS 6561:2015 стандартын дагуу Үйлдвэрлэлийн хаягдал усны найрлага дахь бохирдуулах бодисын агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд зөвшөөрөгдөх дээд хэмжээний шаардлагад нийцтэл цэвэрлэсний дараа хаягдал усыг ариутгах татуургын сүлжээнд нийлүүлнэ. | -Хаягдал усыг цэвэрлэх байгууламж ашиглан хаягдал усны стандартын түвшинд хүртэл цэвэрлэж байгаа нь тогтоогдсон бол цэвэрлэх байгууламж суурилуулан ашигласан өдрөөс эхлэн гурван жилийн хугацаагаар төлбөрөөс чөлөөлнө. |
|   |  | Мөн дээрх журмын 3.2.8-д заасны дагуу хаягдал усыг цэвэрлэн эргүүлэн ашиглах замаар усны нөөцийг 50%- иас дээш хэмнэж, дахин ашиглах боломж бүрдүүлсэн байх (Үйлдвэрийн хүчин чадалд тохирсон бохир ус цэвэрлэх байгууламжтай болох)                                       | Усны нөөцийг хэмнэнэ.  |
| 2 | Агаарын чанар, озон- уур амьсгалын чиглэлээр | Үйлдвэрт болон оффист R-134A, CO <sub>2</sub> бодистой хөргөлт , агааржуулалтын тоног төхөөрөмж сонгох   | Эдгээр бодисууд нь озон задлах чадвар (ОЗЧ) болон дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар (ДДНЧ) багатай.  |
|   |  | Тээврийн хэрэгслийн янданд шүүлтүүр тавих, төслийн үйл ажиллагаанд ашиглах машины техникийн оношлогоо, тохиргоо, үйлчилгээг тогтмол хийж, ашиглалтын нөхцлийг сайжруулах замаар агаарын бохирдлыг багасгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай                        | Автомашинны дутуу шаталтаас үүдэлтэй агаарын бохирдлоос сэргийлэх  |
|   |  | Үйлдвэрийн хашаанд болон замын дагуух хэсэгт мод тарих   | Замын дагуух тоосжилтоос сэргийлэх   |

|   |   |   |   |
|---|---|---|---|
| 3 | Хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр                 | Нийслэлийн ЗД-ын 2013 оны А/623-д захирамжийн дагуу эзэмшил талбайн 20 %-тай тэнцэхүйц хэмжээтэй газарт ногоон байгууламж бий болгох  | Ногоон байгууламж нэмэгдүүлэх замаар хөрсний элэгдэл, эвдрэлийг бууруулах   |
|   |   | Ургамалжуулсан талбайг арчлах, хамгаалах, жил бүр нөхөн тарилт хийх, намар цэнэг услагааг тогтмол хийж занших   |   |
|   |   | Өөрийн эзэмшил, ашиглалтад байгаа болон орчны 50м хүртлэх нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжид холбогдох стандартууд (MNS 5914:2008, MNS 6260:2011, MNS 5342:2007)-ын дагуу тохижилт арчилгаа хийж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх   |   |
|   |   | Эх үүсвэрээс гарах ахуйн хог хаягдлыг болон химийн бодисын сав, баглаа боодлыг ил задгай хаяхгүйгээр зохих журмын дагуу зайлуулах   |   |
|   |   | Тайлангийн 9 дүгээр бүлэг БОМТ-нд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх   |   |
| 4 | Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр        | <p>Хог хаягдлын тухай хуулийн 8.1.9а-д заасны дагуу Аюултай хог хаягдлыг үүсгэгч, тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч бүртгүүлж, бүртгэлийн дугаар авсан байх</p> <p>- Хуулийн 23.6-д зааснаар Аюултай хог хаягдал үүсгэгч нь хуулийн 8.1.4-т заасан тусгай зөвшөөрөлтэй ААНБ-д шилжүүлэхэд хуулийн 8.1.7а- д заасан маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлэх</p> <p>- Мөн хуульд зааснаар зориулалтын саванд хийж, мөн сав нэг бүр дээр "Аюултай хог хаягдал" гэсэн бичиглэлтэй стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэх</p> <p>- Хуулийн 23.4-т зааснаар Аюултай хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр төрлөөр нь бүртгэх</p> |   |
| 5 | Эрчим хүч, энергийн менежментийг сайжруулах чиглэлээр | <p>- Эрчим хүч их хэрэглэдэг хэсгүүдэд тоолуур суурилуулж хэрэглээг хянах Албан ажлын байрны гэрэлтүүлгийг үйлдвэрийн хэсгээс салгаж шаардлагагүй хэсгүүдийн гэрлийг унтраадаг байх,</p> <p>- Мэдрэгчтэй гэрэлтүүлэг суурилуулах,</p> <p>- Гэрэлтүүлгийг LED болгох,</p> <p>- Агааржуулалтын төхөөрөмжийг цагийн механизмтай болгох</p> <p>- Уур, дулааны бүх шугам хоолойг дулаан тусгаарлагч материалаар бүрэх</p>  | Цахилгаан зарцуулалт багатай тоног төхөөрөмжүүдийг сонгон ашигласнаар эрчим хүч болон зардал бууруулах үр дүнтэй. |

|   |  |   |  |
|---|--|---|--|
| 6 | Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа                                     | Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх ажлыг 20-р хорооны үйл ажиллагаанд чиглүүлэх, дэмжих, хамтран ажиллах  | Компанийн хөгжилд чухал нөлөө үзүүлнэ.   |
| 7 | Барилга, байгууламжийн бүтээцийг сайжруулах чиглэлээр              | <ul style="list-style-type: none"> <li>- УБ хотын нарны гийгүүлэл, нарны цацраг нь барилга байгууламжид "хүрэлцээтэй" бүс нутаг тул нарны эрчим хүчийг барилгад ашиглах,</li> <li>- Байгалийн гэрэлтүүлэг болон LED чийдэн ашиглах,</li> <li>- Барилгын дулаан алдагдал хамгийн бага байх хийцтэй,</li> <li>- Бүрэн автоматжуулалт бүхий цахилгааны систем суурилуулах</li> </ul>   | <p>УИХ-ын 2014.06.13-ны өдрийн №43 дугаар тогтоол "Ногоон хөгжлийн бодлого"-ын дагуу</p> <ul style="list-style-type: none"> <li>- Барилгын дулаан алдагдлын бууралтын хувь 20%-иас дээш байна.</li> <li>- Сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь 20%-иас дээш байна.</li> </ul>  |
| 8 | Эрсдэл, аюулгүй ажиллагааны чиглэлээр                              | <ul style="list-style-type: none"> <li>-Химийн бодисын агуулахыг стандартад нийцүүлэн тохижуулах,</li> <li>- Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээ, химийн бодисын аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын сургалтанд хамруулж, хувцас хэрэглэлээр хангаж өмсөж хэвшүүлэх</li> <li>- Үйлдвэрийн орчимд аянга цахилгаантай өдрийн тоо жилд дунджаар 21.1 байдаг тул суурилуулсан аянга цахилгааны газардуулга, зайлуулагчийн бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавих,</li> <li>-Үерийн далан, шуудуутай байх</li> </ul>  | <ul style="list-style-type: none"> <li>- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага. MNS 6458:2014-г хангана.</li> <li>-Хүний эрүүл мэнд, өмч хөрөнгөнд учрах эрсдлээс сэргийлнэ.</li> <li>- Их хэмжээний усархаг аадар борооны улмаас үйлдвэрийн хашаа, агуулах, хогийн цэг, уурын зуух усанд автахаас сэргийлнэ.</li> </ul> |
|   | Хөдөлмөрийн дотоод журмын сургалт                | 2023/02/07  | 2023/02/07   | Төлөвлөгөөт сургалт | ЗХНА                  | Ерөнхий үр чадварын сургалт | Хөдөлмөрийн дотоод журмын сург...       | 76,400.00  | 8              | Дууссан | Нээлттэй |
|   | Хөдөлмөрийн дотоод журмын сургалт                | 2023/02/08  | 2023/02/08   | Төлөвлөгөөт сургалт | ЗХНА                  | Ерөнхий үр чадварын сургалт | Хөдөлмөрийн дотоод журмын сург...       | 210,100.00 | 22             | Дууссан | Нээлттэй |
|   | Үйлдвэрийн албаны сургалт                        | 2023/02/10  | 2023/02/10   | Төлөвлөгөөт сургалт | ҮА                    | Ерөнхий үр чадварын сургалт | Үйлдвэрийн албаны сургалт               | 267,400.00 | 28             | Дууссан | Нээлттэй |
|   | Хөдөлмөрийн дотоод журмын сургалт                | 2023/02/10  | 2023/02/10   | Төлөвлөгөөт сургалт | ЗХНА                  | Ерөнхий үр чадварын сургалт | Хөдөлмөрийн дотоод журмын сург...       | 278,600.00 | 28             | Дууссан | Нээлттэй |
|   | Хөдөлмөрийн дотоод журмын сургалт                | 2023/02/13  | 2023/02/13   | Төлөвлөгөөт сургалт | ЗХНА                  | Ерөнхий үр чадварын сургалт | Хөдөлмөрийн дотоод журмын сург...       | 66,850.00  | 7              | Дууссан | Нээлттэй |
|   | ХАБ, Чанарын бодлого, ХАБЭА нэдлэг олгох сургалт | 2023/03/29  | 2023/03/29   | Төлөвлөгөөт сургалт | ҮА                    | Ерөнхий үр чадварын сургалт | ХАБ, Чанарын бодлого, ХАБЭА нэдл...     | 76,400.00  | 8              | Дууссан | Нээлттэй |
|   | Бргэс хэнх үйлдвэрлэлийн зохицтой дадал          | 2023/08/03  | 2023/08/03   | Төлөвлөгөөт сургалт | ҮА                    | Ерөнхий үр чадварын сургалт | Бргэс хэнх үйлдвэрлэлийн зохицтой дадал | 238,700.00 | 26             | Дууссан | Нээлттэй |
|   | Бргэс хэнх үйлдвэрлэлийн зохицтой дадал          | 2023/09/11  | 2023/09/11   | Төлөвлөгөөт сургалт | ҮА                    | Ерөнхий үр чадварын сургалт | Бргэс хэнх үйлдвэрлэлийн зохицтой дадал | 105,050.00 | 11             | Дууссан | Нээлттэй |



Зураг 7. Сургалтын бүртгэл ба явцаас





Зураг 8. Гал унтраах дадлага сургалтын явцаас



|    |           |  |  |  |  |  |    |  |  |
|----|-----------|--|--|--|--|--|----|--|--|
| 12 |           |  |  |  |  | нурахаас сэргийлэх, хий гишгэж, бүдэрч унахаас сэргийлэх, автомашины хөдөлгөөнөөс болгоомжлох Ачааны лифтэнд сууж явахгүй байх | 10 |  |  |
| 13 |           |  |  |  |  |  | 11 |  |  |
| 14 |           |  |  |  |  |  | 12 |  |  |
| 15 |           |  |  |  |  |  | 13 |  |  |
| 16 |           |  |  |  |  |  | 14 |  |  |
| 17 |           |  |  |  |  |  | 15 |  |  |
| 18 | Dambaгорж |  |  |  |  |  | 16 |  |  |
| 19 |           |  |  |  |  |  | 17 |  |  |
| 20 |           |  |  |  |  |  | 18 |  |  |
| 21 |           |  |  |  |  |  | 19 |  |  |
| 22 |           |  |  |  |  |  | 20 |  |  |
| 23 |           |  |  |  |  |  | 21 |  |  |
| 24 |           |  |  |  |  |  | 22 |  |  |
| 25 |           |  |  |  |  |  | 23 |  |  |
| 26 |           |  |  |  |  |  | 24 |  |  |

|    |               |  |  |  |  |    |  |  |  |
|----|---------------|--|--|--|--|----|--|--|--|
| 18 | Дэлхий мандал |  |  |  | гэмтээхгүй байх, өндөр өрсөн бараа бүтээгдэхүүн нурахаас сэргийлэх, хий гишгэж, бүдэрч унахаас сэргийлэх, автомашины хөдөлгөөнөөс болгоомжлох Ачааны лифтэнд сууж явахгүй байх | 17 |  |  |  |
| 19 | Дан болго     |  |  |  |  | 18 |  |  |  |
| 20 | Дэвч бичир    |  |  |  |  | 19 |  |  |  |
| 21 | Дан зам       |  |  |  |  | 20 |  |  |  |
| 22 | Цэцэг аюул    |  |  |  |  | 21 |  |  |  |
| 23 | Албан ахуй    |  |  |  |  | 22 |  |  |  |
| 24 |               |  |  |  |  | 23 |  |  |  |
| 25 | Баргадөрж Ч.  |  |  |  |  | 24 |  |  |  |
| 26 | З. Билсүүн    |  |  |  |  | 25 |  |  |  |
| 27 | Албан ахуй    |  |  |  |  | 26 |  |  |  |
| 28 | Цэцэг ахуй    |  |  |  |  | 27 |  |  |  |
| 29 |               |  |  |  |  | 28 |  |  |  |
| 30 |               |  |  |  |  | 29 |  |  |  |

**Зураг 9. “Химийн бодисын хэрэглээ ба аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлага” Сургалтын явц ба зааварчилгааны бүртгэл**



**Зураг 10. Галын бэлэн байдал**



Зураг 11. Эмнэлгийн анхны тусламжийн бэлэн байдал

“ТБТ Трейдинг” ХХК УНТ-АТХХХХОАЖ

**“АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАС, ХУВИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙГ ОЛГОХ, АШИГЛАХ ЖУРАМ”**  
УНТ-АТХХХХОАЖ

| АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАС, ХУВИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙГ ОЛГОХ, АШИГЛАХ ЖУРАМ |              |                         |                                     |  | Код:<br>УНТ-АТХХХХОАЖ<br>2017-08-01 |
|---|--------------|-------------------------|-------------------------------------|--|-------------------------------------|
| Огноо   | Овог нэр     | Албан тушаал            | Гарин үсэг                          |  |                                     |
| 2017-04-20  | Ч.Оюунбилэгч | ЧХА-ны дарга            |                                     |  |                                     |
| Хэлэлцсэн:  | 2017-04-25   | Хэлэлцүүлэгт оролцогчид | Чаларын баг                         |  |                                     |
| Хянаж баталсан:   | Ц.Тогсоо     | Д.Б. Чаларын баг        |                                     |  |                                     |
| Хүчин төгөлдөр мөрдөж эхлэх хугацаа:                                  |              |                         | 2017-08-01                          |  |                                     |
| Биеэцгийг хариуцагч нэр:  |              |                         | ТБТ-трейдинг ХХК-ийн нийт ажлааруул |  |                                     |

| Өөрчлөлт хийсэн тухай бүртгэл: |                              |                    |         |                |                |
|--------------------------------|------------------------------|--------------------|---------|----------------|----------------|
| №                              | Зүйл заалт, бүлэг, хуульч №: | Нэмэлт өөрчлөлтийн |         |                | Хянаж баталсан |
|                                |                              | Огноо, тушаал №    | Агуулга | Санал оруулсан |                |
|                                |                              |                    |         |                |                |
|                                |                              |                    |         |                |                |
|                                |                              |                    |         |                |                |
|                                |                              |                    |         |                |                |

УЛААНБААТАР ХОТ  
Хуульч Т.О.О

“ТБТ Трейдинг” ХХК Ерөнхий захирлын 2017 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 2017/08-01 тоот тушаалын дагуу

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙН АЖИЛ ҮҮРГИЙН ТУХАЙ ЖУРАМ**

Хамрах хүрээ: “ТБТ ТРЕЙДИНГ” ХХК-ийн Нийт ажлаар  
Эхнийг хадгалах: Ерөнхий захирал  
Хувийг хадгалах: ЗХНА, ХАБЭА  
Хариуцах эзэн: Нийт ажилчинд  
Тангшлах: Нийт ажилчинд  
Хуудасны тоо: 12 хуудас

| Баримт бичгийн өөрчлөлт |             |                 |         |
|-------------------------|-------------|-----------------|---------|
| Хувибар 1               | Он,сар,өдөр | Тушаалын дугаар | Тайлбар |
| Өөрчлөлт хийсэн огноо   |             |                 |         |

2017.02.09

Ажилтнуудын ХАБЭА-н талаар хүтээх үүрэг тодорхой байснаар ХАБЭА-д хүн бүрийн оролцоог хангах, хүн бүр өөрийн хамгийн үнэт өмч амь нас, эрүүл мэндээ сахин хамгаалах, өрөөл бүсэд шаардлага тавихад чиглүүлэх зэргэ талтай юм.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн Ажилч үүргийн амжилт

Зураг 12. Аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, АА-ны дүрэм журам, зааврууд

### 3.1.5 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

| №                              | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ   | Хэрэгжих хугацаа зардал сая.төг | Төлөвлөгөөний  |        |
|--------------------------------|--|---------------------------------|--|--------|
|                                |  |                                 | Гүйцэтгэл ба үр дүн  | Зардал |
| Хуулийн хэрэгжилтийг хангуулах |  |                                 |  |        |
| 1                              | БОМТ-д тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулан | Дотоод зардал                   | БОХАБЭА асуудал хариуцсан орон тооны ажилтантай бөгөөд БОМТ-д тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах дүрмийн дагуу ажилладаг. 2023 онд | -      |

|   |  |               |  |   |
|---|--|---------------|--|---|
|   | үйл ажиллагааг зохион байгуулах, дотоод журам тогтоож мөрдөх   |               | компани нэр болон бүтэц, зохион байгуулалтанд өөрчлөлт орсонтой /ГБТ Трейдинг ХХК -нь “Газар шим үйлдвэр” ХК болсон/ холбогдуулан зохицуулалтын шаардлагад нэмэлт өөрчлөлт орж байгаа болно. /Зураг 12. БОХАБЭА-н асуудлыг зохион байгуулах дүрэм ба бүтэц/  |   |
| 2 | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд нь хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг байгаль орчны хяналтын байгууллагад хүргүүлж байх | -             | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд нь хийж гүйцэтгэсэн бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралтад заасны дагуу тайланг жил бүр хугацаанд нь тайлагнаж ирсэн.  | - |
| 3 | Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгүүлэх  | -             | 2023 онд ХАБЭА ба Нийгмийн харилцааны чиглэлээр ХХААХҮЯ-наас Мэргэжилтэн шалгалт явуулсан бөгөөд БО-ны чиглэлээр аудит албан ёсоор хийгдээгүй.   | - |
| 4 | Байгаль хамгаалахад дүүргийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах  | -             | 2023 оны өдөр Нийслэлийн Баянгол дүүргийн 20 дугаар хорооны иргэдийн нийтийн хуралд Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хийсэн тохижилт үйлчилгээ, их цэвэрлэгээний ажлын талаар тайлан мэдээг хүргүүлсэн бөгөөд 2023 онд хорооны иргэдээс ямар нэгэн санал гомдол ирээгүй болно.   | - |
| 5 | Экологийн паспорт хөтлөх   | Дотоод зардал | Газар шим үйлдвэр ХК-нь 2018 онд шинэ үйлдвэрийн байрыг ашиглалтанд оруулсан бөгөөд үйл ажиллагаанаас гарах хог хаягдалыг хадгалах, зайлуулах, орчны бохирдол бий болгож үүсгэхгүй байх, гал түймэр гарах эрсдэлийг бууруулах, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулахад чиглэсэн бодлого барьж ажиллаж ирсэн бөгөөд дараах бүртгэлүүдийг тогтмол бүртгэж хяналт, мониторинг, дүн шинжилгээ хийж тасралтгүй сайжруулах бодлого барьж ажилладаг. Хийгдэж буй бүртгэлүүд.<br><ul style="list-style-type: none"> <li>- Химийн бодис, пестицидийн хэрэглээ, хадгалалт хамгаалалт</li> <li>- Эрчим хүчний зарцуулалт</li> <li>- Усны хэрэглээ</li> <li>- Бохир ус</li> <li>- Хог хаягдлын хяналтын бүртгэл</li> </ul> |   |

|                            |   |     |   |      |
|----------------------------|---|-----|---|------|
|                            |   |     | - Тээврийн тухай бүртгэл мэдээлэл.  |      |
| Ажиллагсадыг чадавхижуулах |   |     |   |      |
| 6                          | Ажилчдыг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтанд тогтмол хамруулах, чадавхижуулах                                      | -   | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтыг дараах төрлөөр зохион байгуулсан.<br>- Үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл бүхий болон тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтны сургалтанд 42 хүн хамрагдсан.<br>- Шинээр ажилд орж байгаа иргэний сургалт 256 хүнд<br>- Нийт ажилтны сургалтыг 4 удаа /Алба тус бүрээр тусдаа/ зохион байгуулж 151 хүнийг хамруулсан.<br>- Үүнээс гадна АА-ны зааварчилгаа мэдээллээр бүрэн хангаж ажилладаг. <b>Зураг 13.</b> АА-ны зааварчилгаа, мэдээлэл | 1.2  |
| 7                          | Онцгой байдлын хэлтэстэй хамтран ажиллах гэрээ байгуулж, гэнэтийн осол, эрсдэл, түүнээс хамгаалах талаар сургалт зохион байгуулах | -   | ОБЕГ-ын Үндэсний аврах бригадтай хамтран ажилласан ажлын хүрээнд Алба нэгжийн хариуцлагатай ажилтнуудад болон компанийн гамшгаас хамгаалах онцгой байдлын штабын гишүүдийг хамруулсан сургалт, дадлагыг зохион байгуулсан.<br><b>Зураг8.</b> ОБ-ын үеийн бэлэн байдлын сургалтын явц  | -    |
| Бусад                      |   |     |   |      |
| 8                          | Үйлдвэр ажлын байрны дүгнэлт гаргуулах  | -   | 2024 оны 1-р улиралд шинэ нэр төрлийн бүтээгдхүүн үйлдвэрлэх ажлыг хүрээнд шинээр 6 ажлын нэмэгдэж байгаатай холбоотой Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг 2024 оны 5-р сард хийлгэхээр урьдчилсан байдлаар төлөвлөөд байна.  | -    |
| 9                          | Үйлдвэрээс гарах дайвар бүтээгдэхүүний хаягдлыг хувь хүн, албан байгууллагуудад борлуулахдаа тус бүр гэрээ байгуулах              | -   | 2023 онд үйлдвэрээс гарсан дамжлага дундын болон зөөвөр, тээвэрлэлтийн явцад битүүмж алдагдсанаас яангилаан ялгалтаар чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг акталж малчдад гэрээгээр нийлүүлдэг.<br><b>Хавсралт 7.</b> Хаягдал болон акталсан бүтээгдхүүн худалдах, худалдан авах гэрээ   | -    |
| 10                         | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд холбогдох байгууллагуудаас гарч   | 2.0 | Компанийн эзэмшлийн бүх зам талбай битүү бетонон хучилттай. Харин орчны 50 м -т хамаарах 40 м.кв талбайд шинэсний 10 суулгац  | 0,55 |


|                                      |   |      |      |
|--------------------------------------|---|------|------|
| буй шийдвэрүүдийг хэрэгжүүлж ажиллах | тарьж, мөн цэвэрлэгээ, арчилгаа, үйлчилгээг хариуцан ажиллаж байна. | Нийт | 1,75 |
|--------------------------------------|---|------|------|

“ГБТ Трейдинг” ХХК ЧУМГ-ХАБЭА-н дүрэм

**“ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ДҮРЭМ”**  
/ЧУМГ-ХАБЭА-н дүрэм/

|  |  |                      |                                   |
|--|--|----------------------|-----------------------------------|
| “ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ДҮРЭМ” |  |                      | Код: энг-ХАБЭА-н дүрэм 2018-09-01 |
| Огноо  | Огноо нэр                                      | Албан тушаал         | Гарын үсэг                        |
| Боловсруулсан: 2018-08-20  | Ч.Оюунбилэг                                    | ХАБЭА-н албаны дарга | <i>[Signature]</i>                |
| Хэлцсэн: 2018-08-25  | Ц.Төгсөө                                       | Дэлгэцхирэл          |                                   |
| Хэлцсэн нэ: Огноо:   | Хэлцсэнүүдт өрсөлдөн бүрэлдэхүүн: ажлын хэргэ/ |                      |                                   |
| Хүчин гэрээгээр зарлаж хэргэ хувиар: 2018-09-01  |  |                      |                                   |
| Биестэйг заруулагч нар: ГБТ Трейдинг ХХК-ийн нийт ажилтнууд                            |  |                      |                                   |

| Өөрсдөт хэвсэг тухай бүртгэл: |                 |                    |          |                   |                     |
|-------------------------------|-----------------|--------------------|----------|-------------------|---------------------|
| №                             | Бүлэг, хуудас № | Нэмэлт өөрчлөлтийн |          | ЧМ-ийн гарын үсэг | Засирлын гарын үсэг |
|                               |                 | Агуулга            | Шалтгаан |                   |                     |
| 1                             | 308.2           |                    |          |                   |                     |



Зураг 10. БОХАБЭА-н асуудлыг зохион байгуулах дүрэм ба бүтэц

“ГБТ Трейдинг” ХХК-ийн Дотоод хяналтын лаборатори

Нийн судлалын лабораторид ажиллах аюулгүй ажиллагааны дүрэм



- Лабораторид байх үедээ лабораторийн халд ба битүү гутамь тогтмол өмсөнө.
- Шинжилгээг хийхийн өмнө өрөөг ариутгаж, ариун нөхцөлд стандартын дагуу шинжилгээг үзэн зөв гүйцэтгэнэ.
- Халдвартай материалыг бүрэн халдваргүйбсүүлж устгана.
- Лабораторид шинжилгээг гүйцэтгэхдээ зориулалтын,аюулгүй багаж төхөөрөмжийг урьлаас зөв тохорвоож ашиглана.
- Шинжилгээг хийхээс өмнө заавал шинжилгээний аргын стандарттай тэнцэж сорилыг гүйцэтгэнэ.
- Шинжилгээ хийхээс өмнө багаж тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны заавартай танилцана.
- Шинжилгээг эхэлхийн өмнө лабораторийн эрхлэгчид танилдуулж зөвшөөрөл авна.
- Ямар нэг гэмтэл,осол гарсан тохиолдолд лабораторийн эрхлэгчид тэр дор мэдэгдэнэ.
- Шинжилгээ дууссаны дараа хэрэглэсэн багаж төхөөрөмжөө шалтгаанаас салгаж,шил саваа сайтар цэвэрлэн,угааж ариутгана.
- Шинжилгээ дууссаны дараа шинжилгээний үр дүнд тухай бүрд нь лабораторийн эрхлэгчээр хянуулан баталгаажууна.

БАТЛАВ: “ГБТ ТРЕЙДИНГ ХХК” ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ  
...../Ч.ОЮУНБИЛЭГ/

**ЛАБОРАТОРИЙН ОСОЛ ЭНДЭГДЛИЙН ҮЕД ҮЗҮҮЛЭХ АНХНЫ ТУСЛАМЖ**

| Осол , эндэгдэл                       | Анхны тусламж   |
|---------------------------------------|---|
| Шил сав угаахдаа гараа зүсвэл         | Шилний жижиг хэсгүүдийг түүж авна. Дараа нь цусыг маргагц – перманганатын 2% -ийн уусмал , эсвэл танины 3 %- ийн уусмалаар норгосон самбай даавуугаар ижн тавина.             |
| Хувцас шатах үед                      | Зогс , хэвт, өнхөр  |
| Улайгдсан зүйл болон ууранд түлэгдвэл | Түлэгдсэн хэсэгт маргагц хүчлийн калийн ханасан уусмал түрхэнэ. Хэрвээ түлэгдэлт их байвал эмнэлэгт хүргэнэ.  |
| Цахилгаан халаагуурт түлэгдэх         | Бага зэрэгт усаар угаагаад дээр нь нунтаг сод асгаж 1 минут орчим байлгаад цэвэрлэж ондоогний шар уураг түрхэж болно.   |
| Хүчтэй хүчилд түлэгдвэл               | Түлэгдсэн хэсгийг крантын усаар 15 минут сайн угаасны дараа 2 %- ийн содын уусмалаар угаана. Амьсгалаар хордсон бол цэвэр агаарт гаргаж хүчилтөрөгчөөр амьсгалуулах хэрэгтэй. |





Зураг 13. АА-ны зааварчилгаа, сургалтын явц

**3.1.6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь**

| № | Мэдээллийн агуулга   | БОМТ-г хэлэлцүүлэх оролцогч талууд                      | Төлөвлөгөөний |        |
|---|--|---|---------------|--------|
|   |  |   | Гүйцэтгэл     | Зардал |
| 1 | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай  | Иргэд, хорооны ИНХ                                      |               | -      |
| 2 | Төслийн үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэж | Шаардлагатай тохиолдолд сонирхогч талууд, байгаль орчны |               | -      |

|   |   |                                     |   |     |
|---|---|-------------------------------------|---|-----|
|   | буй ажил  | төрийн бус байгууллага              |   |     |
| 3 | Төслийн үйл ажиллагаа- наас хүрээлэн буй орчин ажлын байранд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ авах, хяналт шинжилгээний дагуу хийсэн ажлыг биелэлтийг тайлагнах | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Энэхүү тайланг 2023 оны 12-р сарын 10-ны дотор Нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж, ирэх 2023 оны төлөвлөгөөгөө хуулин дагуу 12-р сардаа багтаан батлуулахаар ажиллаж байна. | 0,2 |
| 4 |   | Нийслэлийн байгаль орчны газар      |   | -   |

### 3.2 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

| Хяналт шинжилгээ       | Дээж авсан байршил  | Давтамж | Шинжилгээний үр дүн | Зардал /мян.төг/ |
|------------------------|---|---------|---------------------|------------------|
| Агаар                  | "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" MNS 4 585:2016   |         |                     |                  |
|                        | Компанийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч агаар бохирдуулах үйл ажиллагаа эрхэлдэггүй бөгөөд харин Хүнсний аюулгүй байдлыг шаардлагад нийцүүлэн үйлдвэрийн дотор орчинд агаарын бохирдлын шинжилгээ хийдэг.             |         |                     |                  |
| Ажлын байрны дуу чимээ | «Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага" MNS 5002:2000   |         |                     |                  |
|                        | ХАБЭА-н шаардлагын хүрээнд Сард 1 удаа ажлыг байрны гэрэлтүүлэг, дуу чимээний хэмжилтийг хийдэг.  |         |                     |                  |
| Хөрс                   | "Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" MNS 5850:2019  |         |                     |                  |
|                        | Компанийн эзэмшлийн бүх зам талбай битүү бетонон хучилттай.   |         |                     |                  |
| Ундны ус               | "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ" MNS 0900:2018   |         |                     |                  |
|                        | Төвлөрсөн шугам болон худгийн уснаас төлөвлөсний дагуу 2 удаа өгөхөөс 1-ийг нь "Номин ЭКО лабораторид өгсөн 2дахыг нь өөрийн үйлдвэрийн дотоод хяналтын лабораторид хийсэн.<br>Хавсралт.9 Цэвэр усны шинжилгээний дүгнэлт |         |                     |                  |
| Хаягдал ус             | "Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага" MNS 6561:2015 /А хавсралт-Үйлдвэрлэл, үйлчилгээнээс гарах хаягдал усанд тодорхойлох үзүүлэлт/   |         |                     |                  |
|                        | Улсын лабораторууд нь төсөл дээр ажиллаж байгаа гэсэн шалтгаанаар шинжилгээ хийхгүй байсан тул НАР ТА лабораторид 1удаа өгсөн.<br>Хавсралт.8 Хаягдал усны шинжилгээний дүгнэлт  |         |                     |                  |

Дүн. 267000

## **Тайлангийн хавсралтууд.**

- Хавсралт 1. Шинэ өргөө ОНӨААТҮГ-тай байгуулсан хог хаягдал тээвэрлэх гэрээ
- Хавсралт 2. Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт
- Хавсралт 3. Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ
- Хавсралт 4. Аюултай хог хаягдлын дагалдах баримт
- Хавсралт 5. Төлбөр төлсөн баримт
- Хавсралт 6. Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах тухай гэрээ.
- Хавсралт 7. Хаягдал болон акталсан бүтээгдхүүн худалдах, худалдан авах гэрээ
- Хавсралт 8. Хаягдал усны шинжилгээний дүгнэлт
- Хавсралт 9. Цэвэр усны шинжилгээний дүгнэлт
- Хавсралт 10. Үйлдвэрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналтын хуудас



БАТЛАВ

БАЯНГОЛ ШИНЭ ӨРГӨӨ ОНӨААТҮГ  
ЗАХИРАЛ Б. МӨНГӨНСҮХ



*Б.Т.Т. Драйвер ХХК*  
/Иргэн, аж ахуйн нэгж/



## ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ, ХУРААМЖ ТӨВЛӨРҮҮЛЭХ ГЭРЭЭ

20 *20* оны *03* сарын *14* өдөр

№ *5/173*

Улаанбаатар хот

### Нэг. Ерөнхий зүйл

Энэхүү гэрээ нь Монгол улсын Хог хаягдлын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 03 сарын 26-ны өдрийн 30 тоот тогтоолын хэрэгжилтийг хангах, Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, үйлчилгээний газруудаас хог хаягдлын хураамж төвлөрүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаанаас бий болсон хог хаягдлыг тээвэрлэхтэй холбогдон гарсан харилцааг зохицуулна.

#### 1.1 Гэрээг:

**Нэг талаас:** Баянгол шинэ өргөө ОНӨААТҮГ /цаашид тээвэрлэгч гэх/,

**Нөгөө талаас:** *АОННБГЦО* тоот улсын бүртгэлийн, *2577127*

тоот регистрийн дугаартай, Баянгол дүүргийн *20* - р хорооны нутаг дэвсгэрт

*Аюулгүйн гүйцэтгэл* чиглэлээр *Драйвер ХХК* нэртэйгээр

үйл ажиллагаа явуулдаг *Б.Т.Т. Драйвер ХХК* /цаашид хураамж

төлөгч гэх/ нар дараах нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

### Хоёр. Хог хаягдал тээвэрлэгчийн эрх, үүрэг

- 2.1 Хог хаягдлын хураамжийн хэмжээг БГД-ийн ИТХТ-ийн **7/04** тоот тогтоолд заасан тарифыг мөрдлөг болгон тогтооно,
- 2.2 Тээвэрлэгч нь гэрээгээр тохиролцсон хуваарийн дагуу хураамж төлөгчийн **АХУЙН** хог хаягдлыг ачиж тээвэрлэнэ,
- 2.3 Тээвэрлэлт саатсанаас хог хаягдал хуримтлагдсан бол графикт зааснаас бусад цагаар нэмэгдэл хүч зохион байгуулан ачуулах арга хэмжээг авна,
- 2.4 Хог хаягдлыг тээвэрлэх тусгай зориулалтын, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, тээврийн хэрэгсэлтэй байх,
- 2.5 Хураамж төлөгч тогтоосон хугацаанд хураамж төлөөгүй талаарх мэдэгдлийг Татварын хэлтэс, эрх бүхий албан тушаалтнаас ирүүлсэн тохиолдолд хог хаягдал тээвэрлэхийг түдгэлзүүлэх, хураамж төлсний дараа тээвэрлэлтийг хэвийн үргэлжлүүлэх, гарсан хохирлыг нэхэмжлэх эрхтэй,
- 2.6 Хог хаягдлын хураамж төлөхийг шаардах, хураамжийг төвлөрүүлэх,
- 2.7 Гэрээт иргэн, ААНБ барилгын болон хатуу, овортой хог хаягдал тээвэрлүүлэх тохиолдолд хураамжийг урьдчилан төлүүлж тээвэрлэлтийг хийнэ,

- 2.8 Хураамжийг хугацаанд нь төлж барагдуулдаг, 50 метр зай дахь нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээг байнга хийдэг, бүх нийтийн их цэвэрлэгээнд идэвх санаачилгатай оролцдог, шилдэг тохижилттой аж ахуйн нэгж, иргэд, үйлчилгээний байгууллагуудыг шагнаж урамшуулах, дээд байгууллагад тодорхойлох эрхтэй.
- 2.9 Хууль тогтоомжид заасан бусад эрх үүргийг эдэлнэ.

### Гурав. Хураамж төлөгчийн эрх, үүрэг

- 3.1 Өөрийн үйл ажиллагаа, үйлчилгээнээс бий болсон хог хаягдлыг агуулах зориулалтын сав /бункер/-тай байх үүрэгтэй,
- 3.2 Хог хаягдлаа зөвхөн тэгтоосон хог хаягдлын цэг буюу бункерт хаяж тээвэрлүүлэх үүрэгтэй,
- 3.3 Өөрийн талбай /хашаа/-с гадагш 50 метрийн зай дахь нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээг хариуцах үүрэгтэй бөгөөд цас орж мөс тогтсон мөн бусад байдлаар бохирдсон тохиолдолд тухайн талбайн цэвэрлэгээг байнга хийж гарсан хог хаягдлыг тухайн бүсийг хариуцсан этгээдээр тээвэрлүүлж байна,
- 3.4 Хураамжийг улирлаар тушаахдаа эхний сарын 20-ны өдөрт багтаан, сараар тушаахдаа тухайн сарын 20-ны өдрийн дотор тушаана,
- 3.5 Өөрийн байр, үйлчилгээний газрынхаа барилга байгууламжинд засвар хийх, ачаа бараа буулгах, бусад үйл ажиллагаанаас бий болсон **барилгын болон овортой, хатуу хог хаягдлыг** тухай бүрт нь гэрээн дээрх утасны дугаараар дуудлага өгч буюу **захиалгаар** тээвэрлүүлэх үүрэг хүлээх бөгөөд рейсний төлбөр төлж тээвэрлүүлнэ,
- 3.6 Хог хаягдал агуулах зориулалтын савыг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэх бөгөөд иргэд, оршин суугчдын ая тухад нөлөөлөхгүй, машин орж гарахад саад учруулахгүй газар байрлуулж, машин чөлөөтэй орж гарах нөхцлийг хангана,
- 3.7 Хог хаягдлын сав /бункерийн/ орчимд машин тэрэг тавиулсны улмаас хог ачих боломжгүй болж машин буцах, хугацаа алдсан тохиолдолд холбогдон гарах хариуцлагыг хүлээнэ,
- 3.8 Хог хаягдлын хураамжийг гэрээгээр тогтсон хугацаанд төлж байх үүрэгтэй, хугацаанд нь төлөөгүйгээс үүдэн гарсан асуудлын бүхий л хариуцлагыг хүлээх бөгөөд хураамжийг нөхөж төлөх үүрэг хүлээнэ.
- 3.9 Зориулалтын цэгээс бусад газарт хог хаягдал хаяхгүй байх үүрэгтэй,
- 3.10 Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдлэгийг ажилтандаа эзэмшүүлж, аюулгүй ажиллагааны шаардлагыг ханган ажиллах,
- 3.11 Тээвэрлэгчийн доголдолтой үйл ажиллагааны талаарх мэдээллийг хариуцсан албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх эрхтэй,
- 3.12 Дүүрэг болон бусад байгууллага, албан тушаалтнаас зарласан уралдаан, аянд идэвхтэй оролцож тодорхой үр дүн үзүүлсэн бол шагнал урамшуулал хүртэх эрхтэй,
- 3.13 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх үүргийг эдэлнэ.

## Дөрөв. Хураамжийн хэмжээ, хураамж төлөлт

- 4.1 Хог хаягдлын хураамжийн хэмжээ нь БГД-ийн ИТХТ-ийн 30 тоот тогтоолд заасны дагуу сарын 2600000, улиралд 7800000, жилд 31200000 төгрөг байна.
- 4.2 Хог хаягдлын хураамжийг сар бүрийн 15-20-ны дотор дүүргийн татварын хэлтсийн үүссэн нэхэмжлэхийн дугаараар e-tax.mta.mn вэб сайтруу хандан төлбөрийн даалгавар үүсгэх цэсийг ашиглан шилжүүлнэ. Татварын лавлах: 1800-1288, БГД-н Татварын хэлтсийн лавлах: 70001288, 21-254427
- 4.3 Хог хаягдлын хураамжийг гэрээнд заасан хугацаанд бүрэн бараглуулаагүй тохиолдолд татварын өр үүсэхийг анхаарч Татварын хэлтэс болон хариуцсан ажилтны шаардлагыг биелүүлж ажиллана.

## Тав. Гэрээ цуцлах, өөрчлөлт оруулах

- 5.1 Гэрээнд өөрчлөлт оруулах, цуцлах болон гэрээтэй холбогдон гарах аливаа асуудлаар хүсэлтээ хууль эрх зүйн асуудал хариуцсан албан тушаалтанд бичгээр гаргаж үндэслэл, шалтгаанаа тодорхой дурдсан байна.
- 5.2 Хууль эрх зүйн асуудал хариуцсан албан тушаалтан уг хүсэлтийг хүлээн авч үндэслэл, шалтгааныг нарийн судалж шийдвэрлэх бөгөөд хэрхэн шийдвэрлэсэн тухай хураамж төлөгч талд мэдэгдэнэ.

## Зургаа. Гэрээний хугацаа

- 6.1 Энэхүү гэрээ нь 2020 оны 03 сарын 19-ны өдрөөс 2022 оны 03 сарын 19-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ. Талууд харилцан тохиролцож энэхүү гэрээг жил тутам сунгана.
- 6.2 Гэрээний хугацаа дууссан боловч талуудын аль нэг нь гэрээг сунгах эсвэл цуцлах санал гаргаагүй тохиолдолд гэрээг дахин 1 жилээр сунгагдсанд тооцно.
- 6.3 Гэрээний хугацаа дууссан боловч хог хаягдлаа ачуулдаг, үйлчилгээ авдаг ААНБ, иргэний төлөх хураамжийн хэмжээ хэвээр хадгалагдах буюу хүчин төгөлдөр байна.

## Долоо. Хамтран хүлээх хариуцлага

- 7.1 Талууд энэхүү гэрээг дангаараа цуцлах эрхгүй.
- 7.2 Талууд аливаа маргаан, үл ойлголцолыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд Шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.
- 7.3 Нийслэл дүүрэг, эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан тусгай болон их цэвэрлэгээний ажилд тээвэрлэгч хамрагдан ажиллах, байгаль цаг уурын онц ноцтой үзэгдэл тохиолдох, хүндэтгэх шалтгаанаар авто зам хаагдсаны улмаас хог ачих боломжгүй болсон, удирдах дээд байгууллагын шийдвэрээр автомашиныг өөр ажилд дайчилсан тохиолдолд хог хаягдал тээвэрлэлтийн хуваарь өөрчлөгдөж болно. Энэ тухай хураамж төлөгч талд урьдчилан мэдэгдэх бөгөөд хог хаягдал тээвэрлэлтийг нөхөж гүйцэтгэнэ.

**Найм. Бусад**

8.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

8.2 Гэрээнд тусгагдаагүй боловч нэмж оруулах, гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

**Ес. Нэмэлт нөхцөл**

9.1.....  
.....  
.....  
.....

**Арав. Нэмэлт өөрчлөлт**

20 ... оны ... сарын ... -ны өдөр талууд харилцан энэхүү гэрээнд дараах өөрчлөлтийг оруулав.

.....  
.....  
.....  
.....

**Арван нэг. Гэрээ байгуулсан талууд**

**Хог хаягдал тээвэрлэгч:**

“Баянгол шинэ өргөө” ОНӨААТҮГ  
-ын гэрээний мэргэжилтэн

Гарын үсэг: О.Умаргал

Тэмдэг:

Утас: 88014277  
Хог хаягдал харилцааны  
тамгаар ашигласан 91913380

Хог тээвэрлэлт болон гэрээтэй холбоотой асуудлаар холбоо барих утас:

Баянгол шинэ өргөө ОНӨААТҮГ

Утас:  
95536263  
91546263  
89686263

БГД-н Татварын хэлтсийн мэргэжилтэн  
Утас: 9191 3380

**Хураамж төлөгч:**

-Н Э.Н. Наран  
албан тушаалтай / Э.Н. Наран

Гарын үсэг: Э.Н. Наран

Тэмдэг:



Утас: 75059933

Ажлын утас: 75059933

Охи хая

Түшмэг 8803 8775  
(2021.04.28) Харилцааны  
ам-ны өргөө  
5675 162





## УСНЫ АШИГЛАХ БОЛОМЖИТ НӨӨЦИЙН ДҮГНЭЛТ

2021 оны 10 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар...186

Улаанбаатар хот

### 1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:

"ГБТ Трейдинг", Улсын бүртгэлийн дугаар: 9011110110, регистрийн дугаар: 2577127 холбоо барих утас: 976-75059933, 976-75059999, Цахим шуудан: info@gazershim.mn

### 2. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллага:

"Цагаан уулын оргил" ХХК, Холбоо барих утас: 976-70131114, 976-99184930

### 3. Төслийн нэр, байршил:

"Жимс, хүнсний ногооны нөөш, ундааны Газар шим үйлдвэр" төсөл, Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах бөгөөд Туул голын сав газарт хамрагдана.

### 4. Тусгай зөвшөөрлийн дугаар, үйлдвэрлэл, үйлчилгээний нэр, төрөл, зориулалт:

"Жимс, хүнсний ногоо нөөшилсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, Ундааны үйлдвэр, Дотоод хяналтын лаборатори, Органик хүлэмжийн аж ахуй"

### 5. Төслийн хүчин чадал, ажиллах горим:

Үйлдвэр нь жилийн 333 хоногт 211 хүн 2 ээлжийн системээр 13 цаг ажиллана. Шинэ ногооны ургац хураалтын үер буюу өргөст хэмх, хүрэн манжин үйлдвэрлэлийн үер 70 хоногийн хугацаанд 150 орчим хүн нэмэлтээр, 24 цаг ажиллуулдаг. Жимс ногооны үйлдвэр нь жилд 756.2 мян.ш шилэнд жимсний компот, 6201 мян.ш шилэнд хүнсний ногоо, 169.4 мян.л Артишок ундаа үйлдвэрлэнэ.

### 6. Усны эх үүсвэр, байршил:

Төрөл: Төвлөрсөн усан хангамж, гүний худаг ундарга 2.8 л/с буюу 241.92 м<sup>3</sup>/хон  
Байршил: 47°53' 58.58", 106°47' 42.01"

### 7. Ашиглах усны хэмжээ:

- Унд ахуйд 211 хүн х 200 л/хон = 42.2 м<sup>3</sup>/хон ус (14,052.6 м<sup>3</sup>/жил)
- 150 хүн х 200 л/хон = 30 м<sup>3</sup>/хон ус (2,100 м<sup>3</sup>/жил)
- Технологийн ус хэрэглээнд  
756.2 мян.ш х 7.1 м<sup>3</sup>/хон = 16.12 м<sup>3</sup>/хон ус (5,369.02 м<sup>3</sup>/жил)  
6201 мян.ш х 9.6 м<sup>3</sup>/хон = 178.76 м<sup>3</sup>/хон ус (59,529.6 м<sup>3</sup>/жил)  
169.4 мян.л х 12.5 м<sup>3</sup>/хон = 6.35 м<sup>3</sup>/хон ус (2,117.5 м<sup>3</sup>/жил)
- Ногоон байгууламжийн усалгаанд  
345 м<sup>2</sup> х 4 л/хон = 1.38 м<sup>3</sup>/хон ус (66.24 м<sup>3</sup>/жил)  
20 ш х 40 л/хон = 0.8 м<sup>3</sup>/хон ус (38.4м<sup>3</sup>/жил)

Нийт 275.61 м<sup>3</sup>/хон (83,273.36 м<sup>3</sup>/жил) ус шаардагдана.

### 8. Дүгнэлт:

Төсөл хэрэгжүүлэхэд унд ахуйн ус хэрэглээнд шаардагдах 72.2 м<sup>3</sup>/хон усыг төвлөрсөн шугамаас авч ашиглана. Технологи, ногоон байгууламжийн усалгаанд шаардагдах 203.41 м<sup>3</sup>/хон усыг "Эйч эс зэт" ХХК-ийн эзэмшлийн худгаас (хамтран ажиллах гэрээ байгуулсан, ундарга 2.8 л/сек буюу 241.92 м<sup>3</sup>/хон) хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна.

### 9. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:

Төслийг хэрэгжүүлэх явцад Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан 2015 оны А-230/127 дугаар тушаал "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэм мөрдөх журам"-ын 2.9 дэх хэсгийг хэрэгжүүлж, ус авах шугам, хоолойн тоолуурын найдвартай үйл ажиллагааг хангаж ажиллахыг "ГБТ Трейдинг" ХХК-д зөвлөж байна.



УСНЫ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.ГАНТОГОХ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**УСНЫ ГАЗАР**


16060 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо,  
Чингүнжавын гудамж, Утас/Факс: (976-51) 26 55 78,  
И-мэйл: contact@mwa.mn

2021.10.25 № 04/946  
танай 2021.10.06-ны № 02/882 -т

**"ГБТ ТРЕЙДИНГ" ХХК-Д**

"Усны тухай" хуулийн 16<sup>1</sup>.4.10 дахь заалтыг үндэслэн Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт орших "ГБТ Трейдинг" ХХК-ийн "Жимс, хүнсний ногооны нөөц, ундааны Газар шим үйлдвэр" төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайлан болон холбогдох материалыг судалж үзээд усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 1: хуудастай.



УСНЫ НӨӨЦИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА *D. Onorjargal* Д.ӨНӨРЖАРГАЛ

163212839

БАТЛАВ. УЛААНБААТАР  
“ТҮМЭН ЭГШИГ” ХХК  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

БАТЛАВ.  
“ГБТ ТРЕЙДИНГ” ХХК  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



...../Г.ЧИНЗОРИГ/

...../Ц.ГАНБАТ/

## АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 03 сарын 21-ний өдөр

№ 12/05

Улаанбаатар хот

Нэг талаас Түмэн эгшиг ХХК /цаашид “Хүлээн авагч” гэх/ төлөөлж Үйлдвэр хариуцсан дарга албан тушаалтай Б.Одбаяр, Нөгөө талаас ГБТ ТРЕЙДИНГ ХХК-г /цаашид “Үүсгэгч” гэх/ төлөөлж албан тушаалтай Лабораторийн эрхлэгч албан тушаалтай Ю.Чулуунцэцэг бид харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

### Нэг. Гэрээний агуулга

- 1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичгийн дагуу түүнээс гарч байгаа аюултай хог хаягдлыг хүлээн авагч нь хүлээн авч хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.
- 1.2. Эл гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол улсын Хог хаягдлын тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3. Аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл болон үнийн талаар гэрээний Хавсралт 1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ дагалдах бичгийг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

### Хоёр. Аюултай хог хаягдалд тавигдах шаардлага

- 2.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэглэгээтэй байна.
- 2.2. Аюултай хог хаягдал савласан сав бүр нь ямар химийн бодис хадгалж байсан тухай нэр шошготой байна.
- 2.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хүлээн авагчид шилжүүлнэ.
- 2.4. Аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ **БОАЖЯ Сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг** бүрдүүлж өгнө.
- 2.5. Аюултай хог хаягдлын савыг суллаж онц хорттой, тэсрэмтгий, шатамхай бодис /тухайлбал цианид натри гэх мэт/ -г тухайн бодисны шинж чанарт тохирсон уусмалаар цэвэрлэсэн байна. Хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.
- 2.6. Үүсгэгч Аюултай хог хаягдлыг “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий Аж ахуй нэгжийн тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлж хүлээн авагчид шилжүүлнэ.

## Гурав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх хугацаа, төлбөр төлөх нөхцөл

- 3.1. Гэрээний үргэлжлэх хугацаа нь 2022 оны .. сарын .. өдрөөс 2023 оны ... сарын .. өдрийг хүртэл 1 /нэг/ жилийн хугацаатай байна.
- 3.2. Эхний нийлүүлэлт нь гэрээ байгуулагдсанаас хойш 10 хоногийн дотор үүсгэгч нь хүлээн авагчид шилжүүлсэн байна.
- 3.3. Энэхүү гэрээний 1-р хавсралтад заасан Үүсгэгчээс гарах хаягдлын урьдчилсан төлөвлөгөөний дагуу аюултай хог хаягдалын хуримтлал үүссэн тохиолдолд үүссэн хаягдлын хэмжээнээс хамаарч 90-ээс 180 хоногт аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлсэн байна.
- 3.4. Үүсгэгч нь аюултай хог хаягдлаа шилжүүлэх тухай хүсэлтээ хүлээн авагчид албан бичгээр эсвэл [chemicalwasterisk@gmail.com](mailto:chemicalwasterisk@gmail.com) хаягаар 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ. Хүлээн авагч тал үүсгэгч болон тээвэрлэгчтэй харилцан тохиролцож хүлээн авагчийн байранд аюултай хог хаягдал хүргэх хугацааг товлон.
- 3.5. Хүлээн авагч нь үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжин ирэх товлосон өдөр, цагт аюултай хог хаягдлыг хүлээн авах хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.
- 3.6. Аюултай хог хаягдлыг хүлээн авагч хүлээн авах үед үүсгэгчээс ирүүлсэн дагалдах бичигт дурдсан мэдээлэл зөрсөнөөс үүдэж гэрээний үнэ өөрчлөгдөж болно. Энэ тохиолдолд хог хаягдлыг хүлээн авах үед тооцож гаргасан үнээр бодож үүсгэгч хүлээн авагчид төлбөрийг төлнө.
- 3.7. Үүсгэгч нь гэрээний төлбөрийг аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэх тухай захиалга өгсөнөөс хойш ажлын 3 хоногийн дотор Түмэн эгшиг ХХК-ийн **Худалдаа хөгжлийн банк 499085408** тоот дансанд төлбөрийн нэхэмжлэхийн дагуу 100 хувь төлнө.
- 3.8. Үүсгэгч нь хүлээн авагчийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр аюултай хог хаягдлыг тээвэрлүүлж, хүргэлтийн цэг дээр хүргүүлж болно. Хүлээн авагчийн тээврийн хэрэгслээр хог хаягдал ачиж, тээвэрлүүлэх тохиолдолд тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулан, гэрээний дагуу зохих төлбөрийг төлнө.

## Дөрөв. Талуудын эрх, үүрэг

- 4.1 Үүсгэгчийн эрх, үүрэг:
  - 4.1.1 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа гэрээнд заасан хугацааны дотор хүлээн авахыг хүлээн авагчаас шаардах эрхтэй.
  - 4.1.2 Үүсгэгч нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүлээлгэн өгнө.
  - 4.1.3 Үүсгэгч нь Аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 2 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө бичгийг буцаан авна.
  - 4.1.4 Аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүргэх тээврийн зардлыг хариуцна.
  - 4.1.5 Үүсгэгч Аюултай хог хаягдлыг хүлээн авагчаар тээвэрлүүлэхээр бол тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулах харилцан тохиролцож шилжүүлнэ.
  - 4.1.6 Гэрээгээр тохиролцсон төлбөрийг хүлээн авагчид хугацаанд нь төлнө.
  - 4.1.7 Шилжүүлэх аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг хүлээн авагчид үнэн зөв мэдээлнэ. Худал, буруу ташаа мэдээлсэнээс бусдын эрүүл мэнд, амь нас, талуудын эд хөрөнгө болон байгаль орчинд хохирол учирвал үүнээс үүсэх хохирлыг үүсгэгч тал хариуцна.
  - 4.1.8 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа хүлээн авагчид шилжүүлэх тухайгаа 5-аас доошгүй хоногийн өмнө хүлээн авагчид мэдэгдэнэ.

## 4.2 Хүлээн авагчийн эрх, үүрэг

- 4.2.1 Үүсгэгчээс Гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авах
- 4.2.2 Үүсгэгчээс шилжүүлсэн аюултай хог хаягдал нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангаагүй, дагалдах бичигт үл зохицол үүссэн, тоо, хэмжээтэйгээ зөрж байвал уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзах эрхтэй.
- 4.2.3 Үүсгэгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр аюултай хог, хаягдлыг гэрээнд заасан буюу товлосон хугацаанаас 30-аас дээш хоногоор хүлээн авагчид шилжүүлэлгүй хоцроовол хүлээн авагч тал гэрээг нэг талын санаачлагаар цуцлах эрхтэй.
- 4.2.4 Аюултай хог хаягдал хүлээн авсан төлбөр тооцоог үүсгэгчээс гэрээнд заасан хугацааны дотор төлөхийг шаардах эрхтэй.
- 4.2.5 Аюултай хог хаягдлыг хүлээж авсан актыг үүсгэгчид гаргаж өгнө.
- 4.2.6 Хүлээн авагч аюултай хог хаягдлыг хүлээн авсанаас хойшхи түүний хадгалалт, устгал, дахин боловсруулалтыг хариуцна.
- 4.2.7 Үүсгэгчээс Аюултай хог хаягдал шилжиж ирэх үед хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

### **Тав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх, шилжүүлэн авах**

- 5.1. Үүсгэгч гэрээгээр тохиролцсон хугацаандаа аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг буюу Төв аймаг, Сэргэлэн сум, 4-р багийн нутаг дэвсгэрт орших “ТҮМЭН ЭГШИГ ХХК БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР”-т хүргэнэ.
- 5.2. Үүсгэгч гэрээнд заасан шилжүүлэх хугацаанаасаа өмнө аюултай хог хаягдлыг шилжүүлэх эрхтэй ба ингэх тохиолдолд Хүлээн авагчид энэ тухай 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдсэн байна.
- 5.3. Үүсгэгч аюултай хог хаягдлаа “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн тусгай зориулалтын, зохих тэмдэг тэмдэглэгээтэй тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлэн Хүлээн авагчид хүргэж өгнө.
- 5.4. Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэхдээ дагалдах бичиг болон гэрээнд заасан тоо, хэмжээтэй нийцэж байгаа эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгах ба нийцэж байвал энэ тухай акт үйлдэж гарын үсэг зурж хүлээн авагч тал хүлээн авна.
- 5.5. Аюултай хог хаягдал нь гэрээний 4.2.2-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд хүлээн авагч хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзаж болно. Энэ тохиолдолд Аюултай хог хаягдлыг үүсгэгчид буцааж хүргэхтэй холбогдон гарах зардлыг үүсгэгч тал хариуцна.

### **Зургаа. Өмчлөх эрх шилжих**

- 6.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл хог хаягдлын өмчлөгч байна.
- 6.2. Үүсгэгч нь хог хаягдлыг хүлээн авагчид ачиж, тээвэрлэн хүлээн авах цэг дээр хүлээлгэн өгснөөр өмчлөх эрх хүлээн авагчид шилжсэн гэж үзнэ.
- 6.3. Аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг дээр хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл түүний үр шим, эрсдэл үүсгэгчид байх ба хүлээн авагчид хүлээлгэн өгснөөр үр шим, эрсдэл хүлээн авагчид шилжинэ.

### **Долоо. Хариуцлага, маргаан шийдвэрлэх журам**

- 7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.
- 7.2. Үүсгэгч энэ гэрээний 3.8-д заасны дагуу үнийг төлөх хугацааг хэтрүүлсэн бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Хүлээн авагчид төлнө.
- 7.3. Хэрэв Хүлээн авагч нь Үүсгэгчээс ирүүлсэн хог хаягдлыг энэ гэрээний 3.4-т заасан хугацааны дотор зохих журмын дагуу хүлээн аваагүй, хугацааг хожимдуулсан бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гэрээгээр тохиролцсон үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Үүсгэгчид төлнө.
- 7.4. Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10%-аас хэтрэхгүй байна.
- 7.5. Талууд гэрээнээс татгалзах болон цуцлах үндэслэлийг иргэний хуулиар зохицуулна.
- 7.6. Үүсгэгч тал аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэхдээ дагалдах бичиг болон гэрээний хавсралт 1-д заасан тоо хэмжээ, химийн бодисын нэр хаягийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй бөгөөд буруу, зөрүүтэй худал мэдээлсэнээс болж гэрээний үнийн дүн өөрчлөгдөх, эсвэл үүнээс үүдэж хохирол учирвал хүлээн авагч хариуцахгүй болно.
- 7.7. Энэ гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

### **Найм. Давагдашгүй хүчин зүйл**

- 8.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, зуд болох, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг, ажил хаялт, үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг талуудын үйл ажиллагаанаас үл хамаарах үндэслэлээр энэхүү гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.
- 8.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй тохиолдолд талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээний хугацаа дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдах буюу тодорхой хугацаа зааж сунгаж болно.
- 8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа материал устсан, дутсан тохиолдолд шилжүүлэн хүлээлгэн өгөх хүртэлх эрсдэлийг үүсгэгч, шилжүүлэн хүлээн авснаас хойшхи эрсдэлийг хүлээн авагч хариуцна.
